

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ГАНБОЛДЫН НАНДИНЖАРГАЛЫН 2017 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН
ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ИЛТГЭХ ХУУДАС
/2017.01.02-12.28/

НЭГ.ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1.Төсвийн шууд захирагчийн үүргийн биелэлт

1.1.Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-ний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан тусгай арга хэмжээнээс бусад **100 нийт арга хэмжээ (гарц)-ний** хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 1

<i>Тусгай арга хэмжээнээс бусад хэрэгжүүлбэл зохих нийт арга хэмжээний тоо</i>	<i>Өгвөл зохих оноо</i>	<i>Өгсөн оноо /дундаж оноо/</i>
1	2	3
	0-30	27,48

1.2.Гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон **85 тусгай арга хэмжээ (гарц)-ний** хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 2

<i>Хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний тоо</i>	<i>Өгвөл зохих оноо</i>	<i>Өгсөн оноо /дундаж оноо/</i>
1	2	3
	0-40	34,59

1.3. Манлайллын зорилт (орц) бүрийн биелэлтийг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 3

<i>Манлайллын зорилт (орц)-ын тоо</i>	<i>Өгвөл зохих оноо</i>	<i>Өгсөн оноо /дундаж оноо/</i>
1	2	3
	0-30	30,0

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт /өөрийгөө хөгжүүлэх/-ын биелэлт:

.....

1.5. Тухайн төсвийн шууд захирагчийн төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажилласан тухай дүгнэлт:

.....

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийн биелэлт:

.....

ХОЁР. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3. Гэрээний биелэлтийн үнэлгээ

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж, дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 4

Гэрээний үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
1. Нийт арга хэмжээ (гарц)-ний биелэлт	0-30	27,5
2. Тусгай арга хэмжээ(гарц)-ний биелэлт	0-40	34,6
3. Манлайллын зорилт (орц)-ын биелэлт	0-30	30,0
Нийт оноо	0-100	92,1

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээгээ гэж тэмдэглэнэ.

Хүснэгт 5

"А" буюу "Маш сайн"	"В" буюу "Сайн"	"С" буюу "Хангалттай"	"D" буюу "Дутагдалтай"	"F" буюу "Хангалтгүй"
☐	☐	☐	☐	☐

Хэрэв "А" буюу "Маш сайн", эсхүл "D" буюу "Дутагдалтай", "F" буюу "Хангалтгүй" гэсэн үнэлгээ өгсөн бол энэ тухай үндэслэлээ бичнэ:

.....

4. Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1).....

2).....

.....Г.М.

5. Гэрээний биелэлтийн үнэлгээний баталгаажуулалт:

5.1. Үнэлгээ өгсөн:

Төсвийн ерөнхийлөн захирагч

САЙД
(албан тушаал)
(тэмдэг)

.....
(гарын үсэг)

/Д.СУМЪЯАБАЗАР/

.....
(огноо)

5.2. Үнэлгээтэй танилцсан:

Төсвийн шууд захирагч

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
(албан тушаал)
(тэмдэг)

..... /Г.НАНДИНЖАРГАЛ/
(гарын үсэг)

.....
(огноо)

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
/2017.01.02-2017.12.28/**

НЭГ. ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

ХАХ	ГАҮ	Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)	Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)	
				ХШУДАГ	ТӨЗ
1	2	3	4	5	6
НИЙТ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ					
НЭГ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, САЛБАРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:					
1.1. Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн бодлого, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах гол зорилтын хүрээнд:					
1.1.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:					
2	3	1.1.1.2. Засгийн газрын хуралдаанаар 2017 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг тайлагнана. 1. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд яамны газар, хэлтсээс санал авч нэгтгэн боловсруулж удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.	-Засгийн газрын хуралдаанаар 2017 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, удирдлагуудад танилцуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт цахим хаягаар хүргүүлсэн. -2017 онд Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайдын захирамж 1, Засгийн газрын тогтоол 18, хуралдааны тэмдэглэл 7 нийт 26 асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсан. Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийг яамны удирдлагад тухай бүр танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллаж байна. /Биелэлт-100%/	27	

		Хугацаа: 1 дүгээр сард			
3	4	1.1.1.4. Яамны удирдлагын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөлгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулна. 1. Шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврыг холбогдох газар, хэлтэст хүргүүлэн хяналтад авч биелэлтийг тайлагнана. Тоо хэмжээ: 54 удаа Чанар: Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан байна. Хугацаа: 7 хоног бүрийн Даваа гарагт	-Долоо хоног бүрийн Даваа гаригт Шуурхай хурлыг зохион байгуулж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, тайлагнах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Шуурхай хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтлөн архивлаж, цахим мэдээллийн сан үүсгэн хадгалж байна. -2017 онд шуурхай хуралдаан нийт 41 удаа хуралдсан. Яамны удирдлагууд гадаад улсад томилолттой, хурал, зөвлөгөөнд оролцсон, УИХ, ЗГХЭГ-аас яаралтай дуудагсан зэрэг шалтгааны улмаас шуурхай зөвлөгөөн цуцлагдаж байсан болно. Давхардсан тоогоор 117 удаагийн үүрэг даалгавар өгөгдсөн ба биелэлтийг тухай бүр холбогдох газруудаар гаргуулан авч удирдлагад танилцуулж ажилласан. /Биелэлт-100%/	27	
7	8	1.1.1.8. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах 1. Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны салбар хороог байгуулан ажиллана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төлөвлөгөө боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	-УУХҮЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөл болон тус зөвлөлийн ажиллах журмыг 2017 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн Сайдын А/89 дүгээр тушаалаар батлуулсан. -Жендэрийн салбар зөвлөлийн 2017 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж салбар зөвлөлийн дарга ТНБД-аар батлуулсан. -Салбарын төрийн захиргааны албан хаагчдын хүйсийн судалгааг гарган жендэрийн үндэсний хороонд хүргүүлсэн. -Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь сэдэвт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан. -Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол болон гэр бүлийн хүчирхийллийн асуудал, тэдгээрт холбогдох эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийг талаарх уулзалтад оролцсон. -Монгол, Франц, Европ дахь эмэгтэйчүүдийн эрхийн тэгш байдал, харьцуулсан төлөв сэдэвт семинарт оролцсон. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан Мэдээллийн цагаар хийсэн сургалтуудад хамрагдсан. -Жендэрийн стратеги хөтөлбөрийг боловсруулах ажилтай холбогдуулан Төвийн бүсийн чуулга уулзалтад оролцон суурь судалгааг СЕСМИМ төсөлтэй хамтран хийсэн. -Сесмим төслийн Жендэрийн мэргэжилтэн Алтанцоожтой хамтран Жендэрийн асуудлыг салбарын бодлого хөтөлбөртэй уялдуулах нь сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг УУХҮЯ-ны хурлын танхимд зохион байгуулсан.	30	

			-“Жендэрийн үндсэн ойлголт” сэдвээр ХНХЯ-аас сургалтыг яамны нийт албан хаагчдад “Мэдээллийн цаг”-аар хийсэн. -2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Эрдэс баялгийн салбар ба Жендэр” сэдэвт семинарыг СЕСМИМ төсөлтэй хамтран зохион байгуулсан. /Биелэлт-100%/.		
1.1.2 Хүний нөөцийн удирдлагаар хангах зорилтын хүрээнд:					
13	14	1.1.2.3. Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургаж дадлагажуулах, гадаад, дотоодын сургалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулна. 1.Яаманд ирүүлсэн сургалтын мэдээллийг тухай бүр нь удирдлагад танилцуулж, ажилтан албан хаагчдыг хамруулах арга хэмжээг авч ажиллана. Тоо хэмжээ: 4-өөс доошгүй Чанар: Сургалт зохион байгуулагдсан байна. Албан хаагчдыг хамруулсан байна. Хугацаа: Тухай бүр	Яаманд ирүүлсэн сургалтын мэдээллийг тухай бүр нь удирдлагад танилцуулж, албан хаагчдыг хамруулах арга хэмжээг авч ажилласан. Тайлант хугацаанд яамны албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, чадавхжуулах гадаадын 16 сургалт, семинарт 30, дотоодын 51 сургалт, семинарт 123 албан хаагчдыг тус тус хамруулаад байна. /Биелэлт 100%/	27	
	15	2. 2017 оны сургалтын төлөвлөгөөг гаргана. Тоо хэмжээ: 1, Чанар: Сургалтын төлөвлөгөөг батлуулсан байна. Хугацаа: Төлөвлөгөөний дагуу	Шинээр ажилд орсон албан хаагчдад Төрийн албаны ёс зүй харилцааны соёлын талаар тусгай хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын байрны бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “5С буюу Кайзен менежмент ба байнгын сайжруулалт”, “Харилцааны ур чадвар”, “Цаг төлөвлөлт болон хувийн зохион байгуулалт” сэдвүүдээр Монголын хүний нөөцийн институтээс 2017 оны 12 дугаар сарын 25, 27-ны өдрүүдэд сургалт авахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. /Биелэлт 50%/	15	
14	16	1.1.2.4. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийг нэгтгэн хөтлөх, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан гаргана. - Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийг нэгтгэн хөтөлнө. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тоо бүртгэлийг хөтөлсөн байх Хугацаа: 1 дүгээр сард	Яамны нийт албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг тухай бүрт нь хийж байна. УУХҮЯ нь 2017 оны 12 дугаар сарын 15 ны өдрийн байдлаар нийт 88 ажилтан албан хаагч ажиллаж байна. Бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр ажиллаж байна. 2017 оны Бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг 2018 оны 01 дүгээр сарын 10-нд Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. /Биелсэн 100%/	27	

15	17	1.1.2.5. Яамны ажилтнуудын ажиллах нөхцөл баталгааг хангах, шаардлагатай арга хэмжээ авах, шийдвэрлүүлнэ. 1.Яамны ажилтнуудын ажиллах нөхцөл баталгааг хангах, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах, тайлан мэдээг гаргана. Тоо хэмжээ: 2-оос доошгүй Чанар: Тодорхой үр дүнд хүрсэн байна. Хугацаа: Тухай бүр	УУХҮЯ-ны нийт 78 ажилтан албан хаагчдад шинээр ажлын үнэмлэх олгох, хугацааг сунгах ажлыг зохион байгуулсан. -Төрийн нарийн бичгийн дарга, Сайдын орон тооны бус 5 зөвлөхийн, 7 нэгжийн даргын, бусад удирдлагуудын төрийн ордонд нэвтрэх үнэмлэх авах ажлыг хийж гүйцэтгэсэн. -Сайд, Төрийн нарийн бичгийн даргын автомашины Төрийн ордны нутаг дэвсгэрт нэвтрэх зөвшөөрөл авахад шаардлагатай бичиг баримтуудыг холбогдох журмын дагуу бүрдүүлэн авч өгсөн. -Яамны ажилтнуудын ажиллах нөхцөл баталгааг хангах, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан. Үүнд: УУХҮЯ-нд шинээр томилогдон ажилд орсон албан хаагчдад өрөө, ширээ, сандал, компьютер, өрөөнд утасны дугаарыг шинээр тавиулах, утасны аппаратыг захиалж авч өгөх, өрөө тасалгаануудыг дулаалуулах зэрэг бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах нөхцөлийг нь бүрдүүлсэн. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны өрөө тасалгааны тохижилт, хуваарилалтыг хийж, 42 өрөөний хаягийг шинээр хийлгүүлсэн. Мөн хүндэтгэлийн танхимын таазыг засварлуулсан. Бусад дотоод зохион байгуулалттай холбоотой ажлуудыг тухай бүр зохион байгуулсан. - Хурлын заал болон Хүндэтгэлийн өрөөний зохион байгуулалтыг тухай бүр хийж ажилласан. УУХҮЯ байгуулагдсанаас хойш нийт 504 удаагийн уулзалт, хуралдаан зохион байгуулагдсан байна. /Биелсэн 100%/	27	
16	18	1.1.2.6. Салбарын шагналаар шагнуулахаар ирүүлсэн материалыг хянаж сайдын тушаал гаргана. Салбарын шагналаар шагнуулахаар ирүүлсэн материалыг тухай бүр нь хянаж шийдвэрлэнэ. Тоо хэмжээ: 4-өөс доошгүй Чанар: Холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэр гарсан байна. Хугацаа: Тухай бүр	2017 онд нийт 380 гаруй шагналын хүсэлт ирүүлснээс Монголын уламжлалт цагаан сарын баярыг тохиолдуулан 350, Газрын тосны ажилтны баярын өдрийг тохиолдуулан 150 гаруй салбарын ажилтан, нийт 1000 гаруй салбарын тэргүүний ажилтан, яамны жуух олгох ажлыг зохион байгуулсан байна. Мөн Төрийн дээд одон медалиар шагнуулахаар ирүүлсэн салбарын мэргэжилтэн, ахмад ажилтны материалтай танилцан холбогдох байгууллагад /Аймгуудын засаг дарга нарт/ саналыг тухай бүр хүргүүлж байна. Нийт 21 санал хүргүүлсэн байна. Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан Төрийн дээд одон медалиар шагнуулахаар ирүүлсэн салбарын мэргэжилтэн, ахмад ажилтны материалтай танилцан 888 хуудас бүхий албан бичгийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Яамны 12 ажилтны шагналын материалыг бүрдүүлэн мөн ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. /Биелэлт 100%/	30	
1.1.3 Яамны нийтлэг үйлчилгээ болон өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах зорилтын хүрээнд					

17	19	1.1.3.1. Яамны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. 1. Яамны удирдлагатай уулзах хүсэлтийг хүлээн авч, уулзалтыг зохион байгуулах, удирдлагаас холбогдох албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаа: Тухай бүр	Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын уулзалтыг тухай бүр зохион байгуулж ажилласан. Тайлант хугацаанд УУХҮСайдын оролцсон гадны төлөөлөгчдийн 8 хурал, уулзалт, Дэд сайдын оролцсон 2, ТНБД-ын оролцсон 45 гадаад хурал, уулзалтыг Гадаад хамтын ажиллагааны хэлтэс болон бусад нэгжүүдтэй хамтран зохион байгуулсан. -Яамны удирдлагуудын дотоод нэгжийн дарга нар, ажилтан, албан хаагчидтай уулзах, яамны аппаратын хүрээнд хийх хурал, уулзалт, семинарын цагийн хуваарийг төлөвлөх, газар, хэлтсүүдтэй хамтран зохион байгуулах, үр дүнг удирдлагуудад мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэсэн бөгөөд яамны удирдлагуудаас холбогдох албан тушаалтанд өгсөн үүрэг, чиглэлийг мэргэжлийн нэгжүүдэд тухай бүр хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан. /Биелэлт 100%/	30	
	20	2. Яамны ажилтнуудад хийх “Мэдээллийн цаг”-ийн хуваарийг батлуулан зохион байгуулна. Тоо хэмжээ: 2-оос доошгүй Чанар: Тодорхой үр дүнд хүрсэн байна. Хугацаа: Тухай бүр	2017 онд уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нийт албан хаагчдад хийх “Мэдээллийн цаг”-ийн хуваарийг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Төрийн нарийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу нийт 21 удаа яамны албан хаагчдад мэдээлэл хийсэн байна. Үүнд: -Бясалгал, сэтгэл зүйн талаар мэдээлэл хийх, -Төрийн албан хаагчийн ёс зүй, -ХАСХОМ-ын мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалт, -Байгальд ээлтэй түлшний салбарын эко шинэчлэлийн тухай , -Канадын Төрийн албаны шинэчлэлийн тухай, -Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгдэх 4 аргачлалын талаар сургалт өгөх, -Монгол улсад геологийн салбар үүсэн хөгжсөн түүхэн замнал, -Уул уурхайн тухай хуулийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг, -Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөөний танилцуулга, -Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн танилцуулга, -Уул уурхайн салбарын нөлөөлөл дэлхийн дулааралд, -Монгол Улсын үйлдвэржилтийн газрын зургийн талаарх танилцуулга, -Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн танилцуулга, -Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний биелэлт гаргах талаар мэдээлэл өгөх, -Монгол орны тектоник хөгжлийн тухай, -Зэс хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төслийн танилцуулга,	27	

		-Палеонтологи, олдворуудын тухай, -Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны талаарх танилцуулга, -Цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллүүд: -“Уул уурхайн салбар орон нутгийн өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөө” судалгааны урьдчилсан үр дүнгийн талаар танилцуулга, -“Жендэрийн үндсэн ойлголт” сэдвээр ХНХЯ-аас сургалтыг тус тус хийсэн. /Биелсэн 100%/		
21	3. Ажилтнуудад батлагдсан удирдамжийн дагуу албан томилолт олгох, тайланг хүлээн авах, түүнд хяналт тавьж тайлагнана. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Тодорхой үр дүнд хүрсэн байна. Хугацаа: Тухай бүр	2017 онд дотоод албан томилолтын 85 дугаар олгож бүртгэсэн. Албан томилолтын 83 тайланг холбогдох албан хаагчидаас бүрдүүлж томилолтын тайланг хаасан. -Мэргэжилтнүүд ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, албан томилолттой байх үед бусад ажилтнуудад ажил үүргийг нь түр орлуулан гүйцэтгүүлэх замаар зохицуулалт хийж ажилласан. -Ажилтан бүрийг эзгүй үед орлох хуваарийг гарган ажилтныг томилон газрын хэмжээнд мөрдөн ажилласан. /Биелсэн 100%/	27	
22	4. Яамны бусад гадаад, дотоод арга хэмжээг зохион байгуулна Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: зохион байгуулсан арга хэмжээ оновчтой, хүртээмжтэй байна. Хугацаа: Жилдээ	Тахиа жилийн сар шинийн баяр, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн баяр, Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” 16 хоногийн аяны хүрээнд “Цагаан тууз зүүх аян” зэрэг арга хэмжээг амжилттай зохион байгуулж, яамны нийт албан хаагчдыг хамруулсан. 2017 оны тахиа жилийн сар шинийн баярын өдрийг тохиолдуулан Уул уурхайн салбарын яамнаас тэтгэвэртээ гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. -2017 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Ахмадын баярыг тохиолдуулан ахмадуудад зориулж хүндэтгэл үзүүлсэн. -УУХҮ-ийн Сайд Д.Сумъяабазар шинээр томилогдсонтой холбогдуулан салбарын ахмадуудыг хүлээн авч уулзах уулзалтыг АМГТГ-тай хамтран 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж ажилласан. Уулзалтад салбарын 130 гаруй ахмадууд хүрэлцэн ирж салбарын талаар санал бодлоо солилцон зөвлөмж, зөвлөгөө өгсөн. - Газрын тосны салбар үүсч хөгжсөний 76 жилийн ойн баярын хүрээнд зохион байгуулагдсан Спортын 3 төрөлт тэмцээн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн баярын хүрээнд зохион байгуулагдсан 4 төрөлт тэмцээн, Уурхайчдын спортын их наадамд тэмцээнд амжилттай оролцсон.	27	

			-"Засгийн газрын цом-2017" жил бүр яамдын дунд зохион байгуулагддаг тэмцээний бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Тус тэмцээнд УУХҮЯ-ны баг тамирчид амжилттай оролцож сагсан бөмбөгийн төрөлд эмэгтэй тамирчид - Алт, шатрын төрөлд эрэгтэй- Алт, теннисний төрөлд эрэгтэй - Хүрэл, эмэгтэй 4 дүгээр байранд тус тус шалгарч багийн дүнгээр Хүрэл медаль хүртсэн. /Биелэлт 100%/.		
18	23	1.1.3.2. Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллана. Ирсэн бичгийг танилцуулах, хяналтад авах, явуулах бичиг баримтыг бүртгэж дугаар олгож, хүргүүлнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Тодорхой үр дүнд хүрсэн байна. Хугацаа: Жилдээ	2017 оны 1 дүгээр сарын 2-ноос 12 дугаар сарын 15-ны хооронд яаманд нийт 5368 албан бичиг ирсэн ба үүнээс сайдын нэр дээр 1817 албан бичиг, яамны нэр дээр 3551 албан бичиг ирсэн байна. 5368 албан бичгээс БХЗГ-1296, ТБГ-528, ТЗУГ- 2171, ХШҮДАГ- 115, ГБГ- 519, УУБГ- 339, ХҮБГ-т 396 албан бичиг цохогдон хувиарлагдсан байна. Нийт 5368 албан бичгээс хариутай бичиг 897, хариугүй бичиг 4475 байгаа ба 807 албан бичгэнд хариу хүргүүлсэн. ТЗУГ-т нийт 2171 албан бичиг ирснээс хариутай-556, шийдвэрлэсэн-504, хугацаа хэтэрсэн 52 албан бичиг байна. -2017 онд 2666 бичиг албажуулж холбогдох байгууллагуудад илгээсэн. Ирсэн, явсан бичгүүдээ файл болгон цахимжуулж товъёог бэлтгэн архивт цаг тухай бүрд нь хүлээлгэн өгч сар бүр бичиг хэргийн тайлан гаргаж ХШҮДАГ-т тайлагнаж байна. -Дээд газраас 2017 онд 136 тогтоол, захирамж, хуралдааны тэмдэглэл ирүүлснийг файл болгон бүртгэж, Эрх зүйн акт танилцуулах хуудсаар удирдлагад танилцуулж холбогдох мэргэжилтэнд хүлээлгэж өгсөн. /Биелэлт 100%/	27	
19	24	1.1.3.3. Архивын бичиг баримтыг бүрдүүлэхтэй холбоотойгоор холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэнэ. 1. Цаасан болон цахим хэлбэрээр архивын бичиг баримт бүрдүүлнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хуулийн дагуу зохион байгуулсан байна. Хугацаа: Тухай бүр	-Цахим хэлбэрээр 4 файл, цаасан суурьтай архивын баримт байнга хадгалахаар 47 хадгаламжийн нэгж, түр хадгалахаар 183, 70 жил хадгалахаар 4, санхүүгийн баримт 58 -ийг тус тус үдэж хавтаслан, хаяглаж нийт 292 ХН-ийг хадгалалт, хамгаалалтад авсан. -Сайд, ТНБД-ын 2016, 2017 оны тушаалыг сканердан цахим баримт бүрдүүлэн авсан нь эрэлт хайлт боловсронгуй болохын зэрэгцээ нийтлэг үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байна /Биелэлт 100%/	30	
	25	2. Архивын бичиг баримтын бүртгэл хөтөлж, хадгалах хугацаа дууссан хадгаламжийн нэгжийг устгалд оруулна.	-Архивын анхан шатны бүртгэлүүдийг цаг тухайд нь тогтмол, үнэн, зөв хөтөлж, яамны албан хаагчдад 45 удаа 99 ХН-ийг 1-30 хоногийн хугацаатай олгож, үйлчилгээ үзүүлсэн. 2015 оны ББНШК-ын 3 дугаар хурлаар батлагдсан устгах акт №1-ээс хадгалах хугацаа дууссан 240 ХН-ийг устгалд оруулсан.	30	

		Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хуулийн дагуу зохион байгуулсан байна. Хугацаа: Тухай бүр	-Архиваас шаардлагатай баримтыг гаргаж, байгууллагын удирдлага, зохион байгуулалтын нэгж, салбарын болон сонирхогч байгууллага, хувь хүн, шүүх, цагдаа, авлигатай тэмцэх газар зэрэг төрийн байгууллагыг архивын мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлж нийт 82 удаа 603 хуудас материал хуулбарлан олгосон. Мөн хуулбар үнэн тэмдгийг 273 баримтын 944 хуудас материалд дарж, дээд байгууллага, яамд, агентлаг, УБ хот дахь ЭСЯ-д, шүүх, цагдаагийн байгууллага, банк, ТАЗ, АТГ зэрэг байгууллагуудад тус тус үйлчилгээ үзүүлэв. /Биелэлт 100%/		
20	26	1.1.3.4. Яамны үйл ажиллагааг дотоодод болон гадаадад сурталчлах, танилцуулах 1. Өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтэрч байгаа мэдээллүүдийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, удирдлагад танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажиллана. Тоо хэмжээ: 4-өөс доошгүй Чанар: Мэдээлэл үнэн бодитой байна. Хугацаа: Жилдээ	-2017 онд өдөр тутмын 16 сонинд өдөр бүр анализ хийж, геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хамаарах мэдээллийн товъёог хөтлөн ажиллаж, сонины дугааруудыг архивласан. -Мэдээ, нийтлэл гаргадаг гол вэб сайтуудын мэдээллийг мөн архивлаж байна. -2017 оны 6 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулагдах Яамны нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр тараах Танилцуулга материалыг бэлтгэж, 1000 хувь хэвлүүлэв. /Биелэлт 100%/	27	
	27	2. “Ил тод уул уурхай” сэдэвт хэвлэлийн бага хурлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 4 удаа Чанар: Зохион байгуулагдсан байна. Хугацаа: Улирал бүр	-2017 оны хоёрдугаар улирлын ээлжит бага хурлыг 4-р сарын 26-ны лхагва гаригт зохион байгуулж, “Уул уурхайн салбарын төвийн бүсийн чуулган” болох талаар мэдээлэл хийв. Нийт ТВ, радио, сонин, вэб сайт нийлсэн 21 хэвлэлийн байгууллага оролцов. -2017 оны 04-р сарын 25-нд Эдийн засгийн сэдвээр бичдэг сэтгүүлчдэд уул уурхайн салбарын мэдээлэл өгөх зорилгоор сургалт зохион байгуулав. -2017 оны 06-р сарын 06-нд Налайх дүүрэгт нүүрс олборлогч аж ахуйн нэгжийн зөрчлийг арилгасан талаарх хэвлэлийн бага хурлыг АМГТГ-тай хамтран зохион байгуулж, мэдээллийг олон нийтэд ТВ, сайтуудаар хүргэв. -2017 оны 06-р сарын 08-нд Уул уурхайн сэтгүүлчдэд “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” шинэчлэгдсэнтэй холбоотой мэдээлэл, сургалт зохион байгууллаа. -УУХҮЯам Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Блю скай зочид буудалд "Хариуцлагатай бичил уурхайн төлөө хамтдаа" үндэсний чуулганыг олон нийтэд сурталчлах арга хэмжээг авч ажилласан.	27	

		-2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Шангрила зочид буудалд зохион байгуулагдсан “Тогтвортой хөгжилд уул уурхай” сэдэвт зөвлөгөөнийг олон нийтэд сурталчлах арга хэмжээг авч ажилласан. -2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдах Уул уурхайн салбарын 95 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан олон нийтэд сурталчлах арга хэмжээг авч ажиллаж байна. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар салбарынхаа үйл ажиллагаа, бодлого, зорилтийг олон нийтэд нээлттэй ил тод байлгах үүднээс “Ил тод, хариуцлагатай уул уурхай” сэдэвт хэвлэлийн бага хурлыг 2017 оны 11 дүгээр сарын 01, 12 дугаар сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулж салбарын мэдээллийг олон нийтэд мэдээллэсэн. “Ил тод, хариуцлагатай уул уурхай” хэвлэлийн бага хурлын сар бүрийн эхний долоо хоногийн Лхагва гараг бүрт зохион байгуулахаар тогтсон. /Биелэлт 100%/		
28	3. Яамны цахим хуудас дахь мэдээллийг тогтмол шинэчилнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Мэдээлэл бодитой байна. Хугацаа: Тухай бүр	Яамны сайтын цаг үеийн мэдээ, мэдээллээс гадна Хэлэлцүүлэг, Ил тод байдал, Бидний тухай булангуудыг цаг тухай бүрт нь хөтөлж, яамны сайтын мэдээллийг долоо хоногт 3-4 контентээр нэмж байршуулсан. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудсанд “Хүний нөөцийн ил тод байдал” гэсэн цэсэнд хүний нөөцтэй холбоотой Төрийн нарийн бичгийн даргын тушаалууд, яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, Яамны дотоод зохион байгуулалтын үйл ажиллагааны стратеги, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, хуралдааны тойм, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, “Авлигын эсрэг хамтдаа” цэсэнд яамны 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө, холбогдох хууль тогтоомжууд, -АТГ-тай хамтарсан ХАСУМ, ХАСХОМ, АТҮХ-үүдийн талаар мэдээлэл, мэдлэг олгох сургалт, -АТГ-аас ирсэн шалгалтын ажлын хэсэг яамны удирдлагуудтай хамтарсан уулзалтын тухай мэдээлэл, -АТГ-ын хяналт шалгалтынханд шилэн дансны мэдээллийн байршуулалт, ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа талаар шалгуулж сайшаагдав. -Сар бүрийн уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн статистик мэдээлэл, -Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд сайдын тушаалаар батлагдсан журам, тусгай зөвшөөрлийг талаарх шийдвэрүүд,	30	

			-“Алт-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан зээл авах аж ахуйн нэгж, байгууллагуудад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, -Монголын үйлдвэрлэлийн геологчдын холбооны санаачилгаар зохион байгуулдаг “Монголын геологи, хайгуул” чуулга уулзалт 9 дэх удаагийн чуулга уулзалтын мэдээлэл, -Геологичдын ажил мэргэжлийн уралдааны зохион байгуулах тухай зарлал, -“Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын шинэчилсэн төслийн нээлттэй хэлэлцүүлэг, -“Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн хүлээн авах журам”-ын төслийн хэлэлцүүлэг; -“Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслийн хэлэлцүүлэг; “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын төслийг хэлэлцүүлэг, -“Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох сургалтын талаарх мэдээлэл, -“Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх талаар судалгаа хийж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Монголбанк, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Эрдэнэс Монгол” ХХК, Үнэт металлын сорьцын хяналтын газрын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан талаарх мэдээлэл, -“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК нь евро стандартад нийцсэн Ган бөмбөлгийн үйлдвэрийг 2017 оны 1 дүгээр сарын 28-нд ашиглалтад оруулсан талаар мэдээлэл, -Газрын тос боловсруулах үйлдвэрийн асуудлаар ХҮБГ-ын даргын Өдрийн сонинд өгсөн ярилцлагыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. -Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагуудтай хийсэн уулзалтын мэдээлэл болон ҮТП-ийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, -Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийн төсөл зэрэг мэдээллүүдийг цаг тухай бүр яамны цахим хуудсанд байршуулсан болно. -Мөн “Шилэн дансны тухай” хуулийн хүрээнд: Засгийн газрын шилэн дансанд хуулиар тогтоосон хугацаанд дараах мэдээллүүдийг тавьж, ил тод байдлыг ханган ажиллаж байна. Үүнд: -УУХҮ-ийн сайдын 2017 оны батлагдсан төсөв, түүнд орсон өөрчлөлт -Батлагдсан хөтөлбөр, түүний биелэлт -Худалдан авах ажиллагаанд хийсэн шалгалтын үнэлэлт, дүгнэлт		
--	--	--	--	--	--

			Тендерийн мэдээлэл -Хөрөнгө, зардал гаргах тухай шийдвэрүүд -Хөрөнгийн болон концессын санхүүжилт - УУХҮ-ийн сайдын 2017 оны орлогын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл -УУХҮ-ийн сайдын багцын гүйцэтгэл -Аудитлагдсан тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмж -Засгийн газрын цахим худалдан авах ажиллагааны системд дараах мэдээллүүдийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажиллаж байна. Үүнд: -УУХҮ-ийн сайдын 2017 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө -Дээрх төлөвлөгөөнд орсон өөрчлөлтүүд -Тендерийн үнэлгээний хорооны шийдвэр -Үнэлгээний хорооны бүрэлдэхүүний мэдээлэл -Тендерийн урилга -Хураангуй жагсаалтад орсон тендерт оролцох саналын урилга -Тендерийн баримт бичиг -Тендерт оролцогчдын ажлын даалгавар зэрэг болно. /Биелэлт 100%/		
	29	4. Хоёр сар тутамд англи дээрх мэдээлэл бэлтгэх бөгөөд мэдээллийг яамны вэб хуудсаар дамжуулан түгээнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Мэдээлэл бодитой байна. Хугацаа: Тухай бүр	-Канад Улсын Торонто хотод болсон PDAC-д УУХҮ-ийн сайд оролцохтой холбоотойгоор сайд Ц.Дашдоржийн ярилцлагыг англи хэл дээр гаргаж, олон улсын арга хэмжээний сэтгүүлд нийтлүүлэв. Ярилцлагын монгол хэл дээрх хувилбарыг яамны вэб сайт болон News.mn сайтад гаргав. -2017 оны 5-р сарын 16-17-нд Эрдэнэт хотод болсон Төвийн бүсийн чуулганы талаар дэлгэрэнгүй сурвалжлага бэлтгэн, нийтлэл гарган англи хэлээр хөрвүүлсэн. /Биелэлт 90%/	21	
1.2. ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРАМ, ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, САЙД, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ШИЙДВЭРИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛИЙГ ХЯНАХ, ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД ЯАМЫГ ШҮҮХ АРБИТРТ ТӨЛӨӨЛӨХ ГОЛ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:					
1.2.1 Хууль тогтоомж, дүрэм журам, гэрээ хэлэлцээрийн төсөл боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилтын хүрээнд					
21	30	1.2.1.1. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлнэ.	2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалуудаар ХЗДХЯ-аас сургалт авсан. Яамны нийт албан хаагчдаас 26 ажилтан, албан хаагчид тус сургалтад хамрагдсан. /Биелэлт – 100%/	30	

		1. Яамны нийт албан хаагчдын дунд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийх 6 аргачлалаас эхний 3 аргачлалаар Хууль зүйн яамнаас сургалт авна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Сургалт зохион байгуулагдсан байна Хугацаа: 1 дүгээр сард			
31		2. Яамны нийт албан хаагчдын дунд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийх 6 аргачлалаас сүүлийн 3 аргачлалаар Хууль зүйн яамнаас сургалт авна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Сургалт зохион байгуулагдсан байна Хугацаа: 2 дугаар сард	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Д.Цолмон, Ш.Нарантуяа нарыг оролцуулан яамны нийт ажиллагсдад Хууль тогтоомжийн тухай хуульд заасан сүүлийн 3 аргачлалуудаар сургалтыг 2017 оны 6 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулав. Яамны нийт албан хаагчдаас 20, Ашигт малтмал, газрын тосны газраас 4 албан хаагчид тус сургалтад хамрагдсан. /Биелэлт – 100%/	27	
32		3. Хуулийн төсөл боловсруулах хуулийн төслийг бэлтгэхэд эрх зүйн туслалцаа үзүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хууль тогтоомжид нийцсэн байна Хугацаа: Жилдээ	Хуулийн төсөл боловсруулах хуулийн төслийг бэлтгэхэд эрх зүйн туслалцааг тухай бүр үзүүлэн ажилласан. Үүнд: -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/36 дугаар тушаалаар “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Хуулийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-аар батлуулж, Хуулийн төсөлд санал авахаар бүх яамдууд албан бичиг төлөвлөж ирсэн саналыг нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар оруулж Улсын Их Хурлаар батлуулахад бэлэн болгоод байна. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийг шинэчлэн найруулах, төслийг боловсруулах, хянах, эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байгаа бөгөөд цаг үеийн нөхцөл байдлаас ажлын хэсгийн ахлагчаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хурдан шуурхай, хийж гүйцэтгэж байгаа болно. -ХЗДХЯ болон Германы Хамтын Ажиллагааны Олон Улсын Байгууллагатай хамтран Уул уурхайн салбарын 10 хуулийн давхардал, зөрчил, хийдлийн судалгааг гүйцэтгэн, уг судалгаанд үндэслэн холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг бэлтгэн ХЗДХЯ-нд 2017 оны 12 дугаар	27	

			сарын 7-ны өдөр хүргүүлээд байна. -ЕСБХБ-ны санхүүжилтээр Уул уурхайн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, Уул уурхайн тухай хуулийн төслийг боловсруулахад хамтран ажиллаж байгаа бөгөөд Уул уурхайн тухай хуулийн эхний төслийг хүлээн авч, санал өгөх ажиллагаа хийгдэж байна. Хуулийн төслийг УИХ-ын 2018 оны хаврын чуулганаар хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/64 дугаар тушаалаар “Газрын тосны тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байгаа бөгөөд цаг үеийн нөхцөл байдлаас ажлын хэсгийн ахлагчаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь хурдан шуурхай, хийж гүйцэтгэж байгаа болно. -2018 оны Төсвийн тухай хуулийг дагалдан гарах Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэж, УИХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. -Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахад Түлшний бодлогын газартай хамтран ажиллаж байгаа бөгөөд бусад яамдаас санал авахаар хүргүүлсэн болно. /Биелэлт – 100%/		
22	33	1.2.1.2. Салбарын хэмжээнд нийтэд дагаж мөрдөгдөх хэм хэмжээ тогтоосон актуудыг улсын нэгдсэн санд бүртгүүлэх 1. 2017 оны эхний улиралд багтаан захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэлгүй яамны болон агентлагийн захиргааны хэм хэмжээнүүдийг хуулийн шаардлага хангаж буй эсэхийг шалгасны үндсэн дээр шинэчлэгдсэн улсын нэгдсэн санд бүртгүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хууль тогтоомжид нийцсэн байна. Хугацаа: 1 дүгээр улиралд	Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэлгүй яамны болон агентлагийн захиргааны хэм хэмжээнүүдийг хуулийн шаардлага хангаж буй эсэхийг шалгах ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд салбарын хэмжээнд мөрдөгдөх тушаал, журмыг тухай бүр бүртгүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. УУХҮЯ-ны Сайдын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгох журам”, А/161 тоот тушаалаар батлагдсан “Үйлчилгээний хөлс тогтоох тухай” тушаал болон А/115 тоот тушаалаар батлагдсан “Дүрэм батлах тухай” тушаалуудыг тухай бүр бүртгүүлэхэд туслалцаа үзүүлсэн. /Биелэлт – 90%/	27	
1.2.2. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянах зорилтын хүрээнд:					

23	34	1.2.2.1. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэрийн төсөл боловсруулахад хууль зүйн мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө үзүүлж ажиллана. 1. Сайдын тушаал, албан бичгийн төсөл боловсруулахад хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлж, зөвлөгөө өгнө. Тоо хэмжээ: Өдөр тутам Чанар: Ирүүлсэн төсөлд хууль зүйн, санал дүгнэлтийг өгсөн байна. Хугацаа: Жилдээ	Сайдын тушаал, албан бичгийн төсөл боловсруулахад хууль зүйн мэргэжлийн туслалцааг цаг тухай бүрт нь өгч ажилласан. Үүнд: -Геологийн судалгааны ажлуудын үр дүнгийн тайланг хүлээн авах шийдвэр, -Геологийн судалгааны ажлуудын төсөл, төсвийн тодотголыг батлах шийдвэр, -Судалгааны ажлын заавар боловсруулах тухай шийдвэр, -Шинээр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын даалгавар батлуулах шийдвэр, -Зөвлөх, мэргэшсэн инженер, шинжээч томилох журмын шинэчилсэн төслийг батлах шийдвэр, -Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хил, заагийг тогтоох талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг хангах, яамны удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх; -Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт төлөвлөж буй “Нэйшнл трейдинг энд транспорт групп” ХХК-ийн боловсруулсан “Газрын тосны бүтээгдэхүүн агуулах” төслийн ТЭЗҮ-г хүлээж авах, дүгнэлт гаргах; -“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх; -“Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төсөл боловсруулах, батлуулах; -Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал эрэх хайх ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилт болон цаашид авах арга хэмжээний санал боловсруулах. -Мөн УУХҮЯ-ны Сайдын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан Сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгох журмын төслийг боловсруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн 3768 дугаарт бүртгүүлсэн. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/15 дугаар тушаалаар “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллаж журмын төслийг боловсруулан Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлуулсан. -Төрийн нарийн бичгийн 2017 оны А/72 дугаар тушаалаар байгуулагдсан Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг	27	
----	----	--	---	----	--

		сайжруулах, шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллан журмын шинэчилсэн хувилбарыг олон нийтийн санал авахаар яамны вэбсайтад байршуулсан. -Уул уурхайн сайдын 2013 оны 171 дүгээр тушаалаар батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журам”-ыг шинэчлэх ажилд санал өгөн боловсруулалтын шатанд байна. -УУХҮ-ийн Сайдын 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн А/173 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндэсний геомэдээллийн сан” хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх ажлын хэсэгт орж ажиллаж байна. /Биелэлт – 100%/		
35	2. Төрийн нарийн бичгийн даргын тушаал, албан бичгийн төсөл боловсруулахад хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлж, зөвлөгөө өгнө. Тоо хэмжээ: Өдөр тутам Чанар: Ирүүлсэн төсөлд хууль зүйн, санал дүгнэлтийг өгсөн байна. Хугацаа: Жилдээ	Төрийн нарийн бичгийн даргын тушаал, албан бичгийн төсөл боловсруулахад хууль зүйн мэргэжлийн туслалцааг цаг тухай бүрт нь өгч ажилласан. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргаас Нийслэл иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд 4 албан бичиг, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 11 албан бичиг, Нийслэл дэх захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 1 албан бичиг, АМГТГ-ын орлогч дарга Р.Раднаасүрэнд 1 албан бичиг, ХЗДХЯ-ны ТНБД-д 2 албан бичиг, ГХЯ-ны ТНБД-д 1 албан бичиг, ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осорт 3 албан бичиг, БОАЖЯ-нд 1 албан бичиг, Өмнөговь аймгийн Засаг даргад 1, Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөлд 1, Ачит Ихт 1, Эрдэнэт Үйлдвэр 1, Тогтвортой хөгжлийн стратегийн групп 1, Ин Эдү ХХК 1, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 1, Цагдаагийн ерөнхий газар 1, АМГТГ-ын ХЭЗХ-ын дарга Ж.Батмагнайд 1 албан бичиг, Архивын ерөнхий газрын дэд дарга Г.Билгүүнд 2 албан бичиг, АМГТГ-ын дарга Б.Баатарцогтод 2 албан бичиг, ЭЦГ-ын гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Мөнхбат-д 1 албан бичиг, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа Ж.Наранбаатарт 1 албан бичиг явуулахад хууль зүйн үндэслэл, бичиглэлийн алдаа зэргийг хянаж боловсруулан хүргүүлсэн байна. Тушаал, шийдвэрийн биелэлтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: 1. УУХҮС-ын 2016 оны 30 дугаар тушаалаар байгуулагдсан уул уурхайн салбарын авлигын эрсдэлийг бууруулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, 2016 оны ажлын хэрэгжилтийг дүгнэн 2017 оны төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулсан.	30	

			2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/71 дугаар тушаалаар байгуулагдсан “Олон Улсын хөрөнгө оруулагчидтай хийх дугуй ширээний уулзалт” зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг бүрдүүлэн “Монголын геологи, хайгуул-2017” чуулга уулзалттай хамтран зохион байгуулсан. 3. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж санал хүргүүлсэн. 4. Газрын хэвлийн тухай хуулийг шинэчлэн найруулах хуулийн төслийг боловсруулах хамтын ажиллагааны хүрээнд Австралийн АМЕР төсөлтэй хамтран ажиллаж байна. 5. Сайдын 2017 оны А/166 дугаар тушаалыг хэрэгжүүлэхийн тулд ажлын хэсгийг зохион байгуулах арга хэмжээг авч, ажлын хэсгийн ажиллах нөхцлийг бүрдүүлсэн. Ажлын хэсгийн дүгнэлттэй танилцан холбогдох арга хэмжээг авсан. 6. ТНБДаргын 2017 оны 3 дугаар сарын 18, 6 дугаар сарын 9-ний өдрийн удирдамжуудын дагуу Баянхонгор, Сэлэнгэ, Төв, Дундговь аймгуудын нутагт ажиллан Алт-2 үндэсний хөтөлбөр, бичил уурхай, хууль бус олборлолттой холбоотой сурталчилгаа, танилцуулга хийх, тушаал, шийдвэрийг тайлбарлах арга хэмжээг тухай бүр авч, илтгэх хуудасаар тогтмол тайлагнасан. 7. ТНБДаргын баталсан удирдамжийн дагуу Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Өмнөговь, Дундговь аймгийн нутагт Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны төслүүдийн хээрийн ажилд хийх шуурхай хяналтыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авч ажилласан бөгөөд илтгэх хуудсаар удирдлагад тухай бүрт нь танилцуулсан. /Биелэлт – 100%/		
1.3. САЛБАРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ТАЛААР ГАДААД ОРОН, ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ТУРШЛАГЫГ СУДЛАХ, САНАЛ ГАРГАХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ГОЛ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:					
1.3.2 Монгол Улс болон гадаад улс орнуудын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд шаардлагатай мэдээлэл материал бэлтгэх, зохион байгуулах зорилтын хүрээнд:					
26	40	1.3.2.1. Монгол Улс болон гадаад улс орнуудын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд шаардлагатай мэдээлэл, материал бэлтгэж удирдлагыг зохих дэмжлэг үзүүлж ажиллана.	-Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын хурал 2018 оны 1 дүгээр улиралд зохион байгуулагдана гэж ГХЯ-ны Хөрш орнуудын газраас мэдэгдсэн. Хуралдааны тов тодорхой болох үед яамны төлөөллийг оролцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахаар төлөвлөж байна. -Канад Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын уулзалтын бэлтгэлд зориулж салбарын тухай холбогдох мэдээлэл, танилцуулгыг бэлтгэсэн.	27	

	1. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаанд дэмжлэг үзүүлж ажиллана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуралдаанд оролцсон байна. Хугацаа: 4 дүгээр улирал	-Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын 20 дугаар хуралдаанаар ОХУ-ын Росгеофондод хадгалагдаж буй 1960-1990 оны хооронд Монголын Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны тайлангийн хуулбарыг Монголын талд хүлээлгэн өгөх асуудлаар Монгол Улсын АМГТГ, Оросын Холбооны Улсын Росгеофонд хооронд хэлэлцээр байгуулахаар тохиролцсон. Үүний дагуу ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яамнаас ирүүлсэн хэлэлцээрийн төслийг орчуулж яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Хуулийн хэлтэс болон Ашигт малтмал газрын тосны газраас санал авч боловсруулан Гадаад харилцааны яамны Олон улсын эрхзүйн газраар хянуулсан. Геологийн мэдээлэл хүлээлгэн өгөх тухай хэлэлцээрийн төслийг Монгол, Орос хэл дээр боловсруулан ОХУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Б.Дэлгэрмаад хүргүүлэх саналыг яамны ГХАХ-т уламжилсан. Москва хотод болсон Газрын хэвлий ашиглалтын Монгол-Оросын Ажлын хэсгийн хуралдаанаар 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдөр “Геологийн мэдээлэл хүлээлгэн өгөх тухай” хэлэлцээрийн төслийг эцэслэн байгуулсан. Үүний дагуу уг хэлэлцээрийг ГХЯ-нд албан бичгээр хүргүүлж, “2017 08/03” нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Монголын талын ажлын хэсэг УУХҮСайдын 2017 оны А/169 дугаар тушаалаар байгуулагдан ОХУ-ын Росгеофондод хадгалагдаж байгаа тайлангийн хувийг авах асуудлаар ажиллаж байна. Ажлын хэсгийн зарим гишүүд Москва хотод ажилласан. Биелэлт-100%		
41	2. Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаанд дэмжлэг үзүүлж ажиллана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуралдаанд оролцсон байна. Хугацаа: Жилдээ	Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын хурал 2018 оны 1 дүгээр улиралд зохион байгуулагдана гэж ГХЯ-ны Хөрш орнуудын газраас мэдэгдсэн. Хуралдааны тов тодорхой болох үед яамны төлөөллийг оролцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахаар төлөвлөж байна. <i>/Дүгнэх боломжгүй/.</i>	/-/	
42	3. БНХАУ-тай Монгол Хятадын Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Салбарын Хамтын Ажиллагааны дэд зөвлөлийн хуралдаанаар эрдэс баялгийн салбар дахь хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэхэд дэмжлэг үзүүлж ажиллана Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуралдаанд оролцсон байна.	2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан Монгол Хятадын Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Салбарын Хамтын Ажиллагааны дэд зөвлөлийн хуралдаанд УУХҮ-ийн сайд, сайдын зөвлөх, ХҮБГ-ын дарга нарыг оролцуулж, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын мэдээллээр хангаж, хамтран ажилласан. <i>/Биелэлт 100%/</i>	30	

		Хугацаа: Жилдээ			
	43	4. “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, үүрэг бүхий Монгол, Германы ЗГХК хуралдааныг зохион байгуулж, хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуралдаанд оролцсон байна. Хугацаа: 4 дүгээр улирал	Засгийн газар хоорондын 5 дугаар хуралдааны дараагаар, 2017 оны 02 дугаар сард тус Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын ажлын хэсгийн 5 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган батлуулсан. -Тус хуралдааныг зохион байгуулахтай холбогдуулан Гадаад харилцааны яамны Европын газрын захирал М.Цэнгэг, Засгийн газар хоорондын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ГХЯ-ны ЕГ-ын 1-р нарийн бичгийн дарга О.Гочоодорж нартай уулзаж, хуралдааны товыг эхний байдлаар 2018 оны 02 дугаар сард хийхээр төлөвлөөд байна. Германы талаас товыг эцэслэн тогтооно. /Дүгнэх боломжгүй/	/-/	
	44	5. Монгол-Канадын Засгийн газар хоорондын Дугуй ширээний уулзалтад дэмжлэг үзүүлж ажиллана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуралдаанд оролцсон байна. Хугацаа: 1 дүгээр улирал	Монгол-Канадын ЗГ хоорондын дугуй ширээний 7 дугаар уулзалтыг 03 дугаар сарын 09-ний өдөр Канадын Оттава хотноо зохион байгуулж, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын мэдээллээр хангаж, хамтран ажилласан. /Биелэлт 100%/	30	
	45	6. Монгол-Японы ЗГ, хувийн хэвшлийн худалдаа, хөрөнгө оруулалтын ээлжит зөвлөлдөх уулзалтад дэмжлэг үзүүлж ажиллана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуралдаанд оролцсон байна. Хугацаа: Жилдээ	Монгол-Японы ЗГ, хувийн хэвшлийн худалдаа, хөрөнгө оруулалтын ээлжит зөвлөлдөх уулзалт энэ оны 4 дүгээр улиралд зохион байгуулагдана. Гадаад харилцааны яамнаас хуралдааны товыг зарлана. /Дүгнэх боломжгүй/	/-/	
1.3.3 Яамны удирдлагын гадаад улс орны төлөөлөгч байгууллагуудтай хийх уулзалт, хурал, ёслолын арга хэмжээ, гадаад томилолтыг зохион байгуулах зорилтын хүрээнд:					
27	46	1.3.3.1. Яамны удирдлагын гадаад улс орны төлөөлөгч, байгууллагатай хийх уулзалт, хурал, ёслолын арга хэмжээ олон улсын форумд оролцох ажлыг зохион байгуулна. 1.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны удирдлагатай уулзалт хийх хүсэлтийн дагуу тухай бүр судалж, хоёр талт	УУХҮ-ийн сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нартай уулзалт хийх хүсэлтийн дагуу тухай бүр судалж, хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэхэд дэмжлэг үзүүлж жилийн эцсийн байдлаар 50 гаруй уулзалтуудын ярианы сэдвүүдийг холбогдох газар хэлтсүүдээс санал авч нэгтгэн, зохион байгуулсан. Мөн яамны удирдлагуудын томоохон хэмжээний 2 айлчлал /БНХАУ – 4-р сард, Австрали –7-р сард/ болон салбарын 4 томоохон арга хэмжээг /Эрдэс баялаг ба жэндэр, Тогтвортой хөгжилд уул уурхай, PDAC-2017, IMARC-2017/ зохион	27	

69	127	3.2.10. Тавантолгой, Нарийнсухайтын нүүрсний ордод тулгуурлан барих цахилгаан станцын төслийн талаар Эрчим хүчний яамтай хамтран ажиллана. 1. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллана. Тоо хэмжээ: Тухай бүр, Чанар: Ажлын хэсгийн зорилго, зорилтыг хангаж ажиллана. Хугацаа: жилдээ	Тус асуудлыг ЭХЯ хариуцан ажиллаж байгаа бөгөөд УУБГ-аас 2017 оны 10 дугаар сарын 18-нд 03/2201 тоотойр төслүүдийн явцын талаар тодруулга авсан. -Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 129 дүгээр тогтоолын дагуу “Тавантолгой цахилгаан станц” ХХК байгуулагдан, Японы Марубени корпорацийг хөрөнгө оруулагчаар сонгох хэлцэл хийж, 2016 оны 6 дугаар сард хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан. Холбогдох тооцоо, судалгааны ажлууд хийгдсэн ба ЭХЗХ-ооноос тусгай зөвшөөрлүүд олгосон, одоогоор төслийн үндсэн худалдан авагч болох Оюутолгой ХХК-тай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний хэлэлцээрийг хийж, техникийн болон арилжааны иж бүрэн саналаа боловсруулан 2017 оны 9 дүгээр сард хүргүүлсэн байна. Төслийн санхүүжилтийг босгоход Оюутолгой ХХК-ийн толгой компани болох Рио тинтогоос эрчим хүчний төлбөрийн баталгаа гаргуулах талаар хүсэлт тавиад байна. /Биелэлт-100%/	21	
3.3. Уул уурхайн салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалт, татвар, бүтээгдэхүүний худалдаа, экспортын бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:					
70	128	3.3.1. Жишиг үнийг холбогдох мэдээллийн эх сурвалжаас бэлтгэж, сар бүрийн эхний 10 хоногт нийтэд мэдээлнэ. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар байгуулагдсан байнгын ажлын хэсэгт ажиллаж, зах зээлийн үнийг сар бүрийн эхний 10 хоногт нийтэд мэдээлж, цахим хуудсанд тухай бүр байршуулна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Ажлын хэсгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлж ажиллаж мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байршуулсан байна. Хугацаа: жилдээ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын, Сангийн сайдын хамтарсан Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 358/А/45 тушаалын дагуу байгуулагдсан Байнгын ажлын хэсэг нь АМТ хуулийн 47 дугаар зүйл, МУ-ын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 220 дугаар тогтоол, 2015 оны 102, 103, 488 дугаар тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоолын дагуу Экспорт гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний нөөц ашигласны төлбөр тооцох жишиг үнийг сар бүрийн 10-ны хуралдаанаар хэлэлцэж баталсан. Сар бүр олон нийтэд зарлан мэдээлж байна. /Биелэлт 100%/	30	
71	129	3.3.2. Техник эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон бэлэн төслүүдийг бүх талаар дэмжиж хэрэгжилтийг эрчимжүүлнэ. /ҮЧ-5.4/ /ЭЗСХ-1.3.8/	-2017 онд ЭБМЗ-ийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар нийт 13 удаа, өргөтгөсөн хуралдаан 1 удаа тус тус хуралдаж нийт 131(давхардсан тоогоор) Техник-эдийн засгийн үндэслэлийн төслийг хүлээн авч хэлэлцсэн. Үүнээс шууд хүлээн авсан 36, ажлын шугамаар хүлээн авсан 76, ЭБМЗ-өөр хэлэлцүүлж дахин хэлэлцүүлэхээр буцаасан 19 төсөл байна.	27	

		Нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн уулын баяжуулах үйлдвэрүүдийг ашиглалтад оруулна. Тоо хэмжээ: 3 удаа, Чанар: Ашиглалтад ороход бэлэн болсон үйлдвэр, уурхайн нөхцөл байдалтай танилцаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал боловсруулж ажилласан байна. Хугацаа: жилдээ	-Техник эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн хөрөнгө оруулагч нь тодорхой болсон бэлэн төслүүдийг дэмжиж, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрт тодорхой төслүүдийг тусган Засгийн газрын тогтоолоор батлуулсан. -Ашиглалтад оруулахад бэлэн болсон уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Үүнд: - “Шинь Шинь” ХХК-ийн Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших Улааны холимог металлын далд уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах Комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан. - “Эм Эл Цахиурт Овоо” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутагт орших Цахиурт Овоогийн төмрийн хүдрийн ил уурхай, баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад газрын зүгээс бодлогын дэмжлэг үзүүлэн Сүхбаатар аймгаас 120 гаруй ажилтан авч үйлдвэрийн туршилтын ажлыг эхлүүлсэн -Хөшөөтийн уурхай, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай 2017.11.26-ны өдөр танилцаж, “Мо Эн Ко” ХХК-ийн удирдлага, аймаг орон нутгийн төлөөллүүдтэй уулзан тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэж санал солилцсон. /Биелэлт 100%/		
73	131	3.3.4. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ. /ЗГҮАХ-1.24.2/ /ҮЧ-5.2/ 1.Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Далд уурхайн ажлын гүйцэтгэл 25 хувь гүйцэтгэгдсэн байна. Хугацаа: жилдээ	-Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Хүдрийн далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилт, холбогдох бусад асуудлаар санал солилцож, зөвлөмж өгсөн. Тухайлбал 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Аюулгүй ажиллагааны дүрмийн талаар яам дээр уулзалт зохион байгуулж, санал солилцсон. -Төслийн II шатны бүтээн байгуулалтын ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Тухайлбал 2017 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Өмнөговь аймагт зохион байгуулсан “Уул уурхайн Говийн бүсийн чуулга уулзалт”-ын үеэр Оюутолгойн ордын ил болон далд уурхай, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, бодлогын зөвлөмж өгч, санал солилцсон. /Биелэлт 100%/	30	
74	132	3.3.5. Цагаан суварга төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. /ЗГҮАХХАТ-1.24.3/	-Засгийн газрын 208 дугаар тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөр”-т Цагаан суварга төслийг ашиглалтад оруулахаар тусгасан. Мөн Үндэсний хөгжлийн газраас	30	

		/ҮЧ-5.4/ /ЭЗСХ-1.3.8.6/ 1.Цагаан суварга төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: -, Чанар: бодлогын дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: жилдээ	боловсруулсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т Цагаан суваргын ордыг хамруулж холбогдох санхүүжилтийг Улсын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр тусган оруулсан. -Үндэсний хөгжлийн газраас Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг Засгийн газраар хэлэлцүүлэхтэй холбогдуулан Цагаан суварга уулын баяжуулах үйлдвэрийн төслийг хөрөнгө оруулалт шаардлагатай төслийн жагсаалтад оруулахаар материалыг хүргүүлж, 2017 оны 1 дүгээр сарын 27-28 өдрүүдэд зохион байгуулсан “Салбарын хөгжлийн бодлого төлөвлөгчдийн зөвлөлдөх уулзалт-2” арга хэмжээнд төслийг танилцуулсан. /Биелэлт 100%/		
	133	2.Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ-г Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ. Тоо хэмжээ: -, Чанар: Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан байна. Хугацаа: жилдээ	“Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр байгуулах” төслийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж хийх шинжээчдийн хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 11 сарын А/62 дугаар тушаалаар байгуулан шинжээчдийн нэгдсэн дүгнэлтийг нэгтгэн гаргаж, төсөл боловсруулагч, хэрэгжүүлэгчид хүргүүлэн холбогдох засварыг хийлгэн ЭБМЗ-ийн хуралдаанаар 2017 оны 10-р сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. /Биелэлт 100%/	30	
75	134	3.3.6. Гацууртын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлнэ. /ҮЧ-5.4/ /ЭЗСХ-2.2.1.2/1. Гацууртын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: -, Чанар: бодлогын дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: жилдээ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллаж “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентеррагоулд Монголия ” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Орд ашиглахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Үүнд: мөнх цэвдэг, үйлдвэрлэлийн тэсэлгээ, байгаль орчин, эртний булш бунхан, хүнцэл, орон нутгийн иргэдийн оролцоо зэрэг асуудлаар хамтран ажилласан /Биелсэн-100%/	30	
	135	2.Гацууртын ордыг ашиглах гэрээ байгуулахад оролцоно. Тоо хэмжээ: -, Чанар: Орд ашиглах гэрээнд санал оруулсан байна.Хугацаа: жилдээ	Дэд ажлын хэсэг “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентеррагоулд Монголия ” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулж, “Сентеррагоулд Монголия” ХХК-аас санал авахаар 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн.	30	

			Төслийн хэрэгжилтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч бодлогын дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна. Тухайлбал, ордын нөөцийг өсгөх талаар нарийвчилсан хайгуул, судалгаа нэмж хийх, нөөцийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх зөвлөмжийг өгсөн. Үүний дагуу нөөцийн тодотгол хийж, шинжээчийн хэсгийн дүгнэлт гаргах шатанд байна. /Биелэлт 100%/		
76	136	3.3.7. Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, зах зээлийн судалгааг хийнэ. 1.Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарын зах зээлийн судалгааг боловсруулж удирдлагад танилцуулна. Тоо хэмжээ: тухай бүр, Чанар: Судалгааг хийсэн байна. Хугацаа: жилдээ	Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарын зах зээлийн судалгааг хийх ажлын хүрээнд судалгааны ажилд шаардлагатай мэдээллийг цуглуулан судалгааны ажлын бэлтгэлийг хангаж байна. Тухайлбал: -Уул уурхай, олборлох салбарын 2017 оны I-XII сарын байдлаар мэдээллийг сар бүр боловсруулан нэгтгэн гаргаж байна. Үүнд: Уул уурхайн салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж болон аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, борлуулалт, үлдэгдэл, гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хөдөлмөр, эрхлэлт, экспорт, экспортод гаргасан ашигт малтмалын жишиг үнэ, олон улсын зах зээлийн үнийн мэдээллийг боловсруулан яамны удирдлагад тухай бүр танилцуулж ажилласан. -Канадын Fraser Institute судалгааны байгууллагын Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад бодлогын орчны нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх мэдээллийг 2016 оны байдлаар боловсруулав. -Уул уурхай, олборлох салбарын мэдээллээр тогтмол мэдээллийн санг баяжуулах ажлыг хийж байна. Үүнд: - “Канадын Fraser Institute” 2015-2016; - International Copper Study Group 2002-2017; - U.S. Geological Survey 1997-2017 - World Data Mining 2013-2016; - www.excoal.com - Үндэсний статистикийн хороо - Монголбанк - Гаалийн ерөнхий газар - Татварын ерөнхий газар - Ашигт малтмал, газрын тосны газар - Монголын төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбоо болон бусад эх сурвалжуудаас мэдээллийг цуглуулж цаг тухайд нь яамны удирдлагыг шаардлагатай мэдээллээр ажиллаж байна. /Биелэлт-90%/	27	

	137	2. Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарын төлөвлөлтөөс үүдэлтэйгээр эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгааг хийж удирдлагад танилцуулна. Тоо хэмжээ: тухай бүр, Чанар: Судалгааг хийж танилцуулсан байна. Хугацаа: жилдээ	Уул уурхайн бодлогын газраас Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн Төрийн бус байгууллагатай хамтран “Уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ” судалгааны ажлыг 2017 оны 9 дүгээр сараас эхлүүлсэн бөгөөд 2017.11.29-ний өдөр судалгааны урьдчилсан тайланг хүлээн авч танилцан судалгааны ажлын тайланд өөрчлөлт оруулахаар тогтов. -“Төлөвлөгөөнд санал өгөх тухай” 3/867 тоот албан бичгээр БСШУСЯ-нд Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж дэмжигдсэн нэр бүхий 10 төслийг хүргүүлсэн бөгөөд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх улсын захиалгат шинжлэх ухаан, технологийн төслөөр шийдвэрлүүлэх асуудлуудын жагсаалтад оруулах хүсэлтийг дахин хүргүүлэв. -ТХМ-ийг боловсруулахад АМГТГ-тай уулзалтыг зохион байгуулж, ашигт малтмалын гол нэрийн бүтээгдэхүүний гаргалтыг судлан тохирч, Сангийн яаманд хүргүүлэв. Мөн Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарын төлөвлөлтөөс үүдэлтэйгээр эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгааг хийхэд мэдээллээр хангалаа. -Сар бүр Сангийн яамнаас уул уурхайн салбарын орлогын мэдээг биет хэмжээ болон орлогын төрлөөр авч газар, хэлтсийн дарга нарт хүргүүлэн, УУБГ-ыг мэдээллээр ханган ажиллав /Биелэлт-90%/	21	
77	138	3.3.8. Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар судалж, санал боловсруулна. /ЗГҮАХ-2.66.1/ Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар судалгаа хийж, санал боловсруулж удирдлагад танилцуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Нэгж байгуулагдах талаар санал боловсруулж танилцуулсан байна. Хугацаа: 4-р улирал	2017 оны 10 дугаар сард Уул уурхайн судалгааны нэгж байгуулах асуудлаар санал боловсруулж, яамны удирдлагад танилцуулсан. /Биелэлт-100%/	30	
78	139	3.3.9. Уул уурхайн салбар үүсгэн байгуулагдсаны 95 жилийн ойн арга хэмжээг угтсан арга хэмжээнүүдийг зохион байгуулна. 1.Уул уурхайн салбарын тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын	Монгол улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ой, Монголын уурхайчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 4 бүс нутагт Уул уурхайн салбарын чуулганыг зохион тухай тусган, батлуулсан. /Биелэлт 100%/	30	

		талаар бүсчилсэн зөвлөгөөн зохион байгуулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Санал боловсруулж удирдлагад танилцуулан шийдвэрлүүлсэн байна. Хугацаа: 1-р улирал			
140	2. Уул уурхайн салбар үүсгэн байгуулагдсаны 95 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Төлөвлөгөө батлагдсан байна. Хугацаа: 1-р улирал	-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017.01.13-ны өдрийн А/05 дугаар тушаалаар байгуулагдсан Уул уурхайн салбар үүсэн байгуулагдсаны 95 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ахлан ажиллаж, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. /Биелэлт 100%/	30		
141	3. Бүсчилсэн зөвлөгөөн зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, Баруун, зүүн болон төвийн бүсэд бүсчилсэн зөвлөгөөнийг зохион байгуулна. Тоо хэмжээ: 3 удаа, Чанар: Бүсийн чуулганыг орон нутаг, ТББ, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран зохион байгуулсан байна. Хугацаа: 1-3 дугаар улирал	-Монгол улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутгийн удирдлага, уул уурхайн компанийн дундах үл ойлголцлыг арилгах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр бүсчилсэн чуулга, уулзалтыг зохион байгуулсан. Төвийн бүсийн “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон төвийн бүсд үйл ажиллагаа явуулж буй Уул уурхайн салбарын аж ахуй нэгжүүд хамтран Орхон аймгийн Эрдэнэт хотод 2017 оны 5 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд, Зүүн бүсийн чуулганыг “Хариуцлагатай уул уурхай ба орон нутгийн хөгжил” сэдвийн дор Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод 2017 оны 9 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд, Говийн бүсийн чуулганыг Өмнөговь аймгийн Даланзадгад хотод 2017 оны 11 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд, Баруун бүсийн чуулганыг Ховд аймгийн Жаргалант суманд 2017 оны 11 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Бүсүүдийн чуулганд Улсын Их хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон бусад холбогдох яамдын төлөөлөл, Ашигт малтмал, газрын тосны газар, бусад холбогдох агентлагуудын төлөөлөл, аймгийн Засаг дарга нар, сум орон нутгийн удирдлага, албан хаагчид, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэд судлаачид, ахмадууд, их дээд сургуулиуд, төрийн бус байгууллага, холбоод, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, уурхайчид, иргэд зэрэг 1100 гаруй зочид төлөөлөгчид оролцсон. Бүсүүдийн чуулга, уулзалтаас орон нутаг, аж ахуйн нэгж, байгууллагад тулгамдаж асуудлыг шийдвэрлэхээр уриалга гаргасан. Тус уриалгад тулгамдсан асуудлыг ангилан шийдвэрлэх эрх бүхий	30		

			байгууллагуудад хүргүүлэх, улмаар 2018 оны төлөвлөгөөнд тусган оруулсан. -2017.12.08-ны өдөр “Тогтвортой хөгжилд уул уурхай” сэдэвт бодлогын зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан. /Биелэлт 100%/		
	142	4. Уул уурхайн салбар үүсэн байгуулагдсаны 95 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Нэгдсэн чуулганы арга хэмжээг зохион байгуулсан байна. Хугацаа: 4-р улирал	-2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Уул уурхайн салбар үүсэн байгуулагдсаны 95 жилийн ойн арга хэмжээг угтаж Яамны мэдээллийн цагаар Яамны албан хаагчдад “Уурхайчин би” дууг заасан. -Монгол улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ой, Монголын уурхайчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд ойн нэрэмжит тэмдэг, ном, сонин, сэтгүүл, баримтат кино, гэрэл зургийн уралдаан, оюутны эрдэм шинжилгээний хурал, 12 дугаар сарын 25-нд ойн баярын хурал, концерт, хүндэтгэлийн хүлээн авалт зэргийг зохион байгуулах ажил хийгдэж байна. /Тайлант хугацаанд биелэлт 100%/	30	
79	143	3.3.10. Эрдэс баялгийн бодлогын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчилнэ. 1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар эрдэс баялгийн бодлогын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж үйл ажиллагааг тогтмолжуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Эрдэс баялгийн бодлогын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан байна. Хугацаа: 1-р улирал	-Эрдэс баялгийн бодлогын зөвлөлийн дүрэм болон бүрэлдэхүүнийг шинэчилж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/16 тоот тушаалаар батлуулсан. -ЭББЗ-ийн дүрэм, бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2017 онд хэлэлцүүлэх асуудлын талаарх саналыг холбогдох газар, хэлтсүүдээс гаргуулж нэгтгэх ажлыг зохион байгуулсан. /Биелэлт 100%/	30	
80	144	3.3.11. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулна. 1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчилж, хорооны ажиллах журмыг батлуулж салбар	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/48 тоот тушаалаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны бүрэлдэхүүнийг, салбар хорооны ажиллах журмыг хавсралтаар тус тус батлуулсан. Салбар хороонд ХНХЯ, МХЕГ, АМГТГ болон МАОЭНХ, МҮЭ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл орсон. Салбар хорооны нарийн бичгийн даргаа мэргэжилтэн Н.Амартуул ажиллаж байна.	30	

	хорооны үйл ажиллагааг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж үйл ажиллагаа тогтворжсон байна. Хугацаа: 1-р улирал	-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодын гишүүдийг чадавхжуулах сургалтад хамрагдаж, Салбар хорооны үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө, санхүүжилттэй холбоотой асуудлаар тодруулга авсан. -Салбар хорооны эхний хурлыг 2017 оны 4 дүгээр сарын 7-ны 14 цагт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хурлын зааланд хуралдуулж салбар хорооны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөрийн төслийг танилцуулан, санал авах зэрэг асуудлуудыг танилцуулсан. -Салбар хорооны үйл ажиллагааны хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци болон Монголын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшсэн инженерүүдийн холбоо болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Нэн түрүүнд ХАБ-2017” бага хурлыг 2017 оны 04-р сарын 11-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Corporate Hotel and Convention Center зочид буудлын Event Hall танхимд зохион байгуулахад оролцов. Энэ хүрээнд хурлын удирдах хороонд гишүүнээр ажиллан Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүдийн оролцоог ханган 10 гаруй аж ахуйн нэгжүүд рүү албан бичиг хүргүүлэн, “Оюу толгой” ХХК-ний илтгэл тавих асуудлыг хариуцан ажиллав. “Нэн түрүүнд ХАБ-2017” бага хуралд төрийн байгууллагын 125, гадаадын байгууллагын 1, хувийн хэвшлийн 240, үүнээс уул уурхайн салбараас 80, Эрчим хүчний салбараас 40, барилгын салбараас 25, бусад салбарын 95 гаруй нийт 150 аж ахуйн нэгжийн төлөөлөл, төрийн бус болон сургалтын байгууллагын 20 гаруй нийт 365 төлөөлөгчид оролцлоо. Хурлыг үеэр талууд хэлэлцүүлэг өрнүүлж, зөвлөмж боловсруулан гаргасан ба холбогдох байгууллагууд хэрэгжилтийг хангахад анхааран ажиллаж байна. -Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуй” 176-р конвенцын хэрэгжилтийн эхний жилийн тайланг боловсруулж, ХНХЯ-д хүргүүлсэн. -Салбар хороо нь Уул уурхайн салбарын аж, ахуйн нэгжүүдийн дунд ажлын байрны нөхцөлийн үнэлгээ хийх, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах зэрэг ажлуудыг ХНХЯ болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төв зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар тохиролцоод 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах шатанд явж байна.		
--	---	--	--	--

			-Салбарын ХАБЭА-н дэд хөтөлбөр боловсруулах, зарим аюулгүй ажиллагааны дүрмийг шинэчилж буйтай холбогдуулан салбар хорооны гишүүдийн чадавхжуулахаар Оюутолгой ХХК-ийн ХАБЭА-ын бодлого, хэрэгжилттэй танилцах ажлыг зохион байгуулж байна. /Биелэлт 100%/		
4.0. ТҮЛШ, ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХУВИЛБАР, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:					
4.1. Түлш, газрын тосны салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:					
82	147	4.1.2. “Газрын тосны тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. /ЗГҮАХ 2.63.2/ 1. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж төслийг боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуулийн төсөл боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг баталсан. Ажлын хэсэг нарийвчилсан төлөвлөгөө гарган, АМГТГ-т дэд ажлын хэсэг байгуулж, хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгуулах санал, хуулийн үзэл баримтлал, үндэслэл, холбогдох тооцоолол судалгааны дагуу боловсруулан, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг нэгтгэн боловсруулж ажиллав. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хуулийн давхардал, хийдэл, зөрчилд өгсөн санал, дүгнэлтийн хүрээнд ажлын хэсгийн гишүүд ажиллаж, холбогдох саналыг өгсөн. Хуульд оруулах саналын томъёоллыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд дэд сайдын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 02/2598 тоот албан бичгээр хүргүүлсэн. /Биелэлт-100%/	30	
83	148	4.1.3. “Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-т заасан “газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм” батална. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулан батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамаар бүртгүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	-Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйл, “Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-т заасны дагуу “газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг боловсруулж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудаас санал авахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудсанд байршуулаад байна. -Цахим болон бусад хэлбэрээр ирүүлсэн саналуудыг нэгтгэн, дүрмийн төсөлд тусгах талаар хэлэлцүүлэг зохион байгуулах, эцэслэн боловсруулсан дүрмийн төслийг УУХҮ-ийн сайдын тушаалаар батлуулан, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэхээр төлөвлөж байна. /Биелэлт-90%/	21	

		Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Дүрмийн төслийг боловсруулж, батлуулсан байна. Хугацаа: Жилдээ			
84	149	4.1.4. “Газрын тосны тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан “нөөц ашигласны төлбөр болон, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах” журмыг боловсруулж батлуулна. 1. “Нөөц ашигласны төлбөр болон, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах” журмыг шинэчлэн боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмыг шинэчлэн боловсруулсан. Хугацаа: Жилдээ	Журмын төслийг шинэчлэн боловсруулсан. /Биелэлт-100%/	30	
	150	2. Журмын төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, гэрээлэгчүүдээс саналыг авч тусгана. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журамд санал авсан байна. Хугацаа: Жилдээ	Журмын төслийг эцэслэн боловсруулж, Уул уурхайн Сайдын /хуучин нэрээр/ зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаад байсан. Яамны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт болон Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн 62 дугаар зүйлд “... захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах...”-аар заасны дагуу хэлэлцүүлэг хийхээр ажиллаж байна. Журмын төсөлд санал авахаар 2017 оны 11-р сарын 14-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудаснаа байршуулж, олон нийтээс саналыг авч байна. /Биелэлт-100%/	27	
	151	3. Журмын төслийг батлуулахаар ЗГ-т хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмын төслийг ЗГ-т хүргүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	Журмын төслийг эцэслэн боловсруулж, бүх яамдаас саналыг авахаар 2017 оны 11-р сарын 17-ний өдрийн 01/2432 тоот албан бичгээр хүргүүлэн саналыг авч, саналыг журмын төсөлд тусган Зг-т хүргүүлэхэд бэлэн болгоод байна. /Биелэлт-100%/	27	
85	152	4.1.5. Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан “газрын тосны бүртгэл тооцоо” журмыг боловсруулж батлуулна.	Журмын төслийг шинэчлэн боловсруулсан. /Биелэлт-100%/	30	

		1. “Газрын тосны бүртгэл тооцоо” журмын төслийг шинэчлэн боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмыг шинэчлэн боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ			
	153	2. Журмын төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, гэрээлэгчдээс саналыг авч тусгана. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмын төсөлд санал авсан байна. Хугацаа: Жилдээ	Журмын төслийг эцэслэн боловсруулж, Уул уурхайн Сайдын /хуучин нэрээр/ зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаад байсан. Яамны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт болон Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн 62 дугаар зүйлд “... захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах...”-аар заасны дагуу хэлэлцүүлэг хийхээр ажиллаж байна. /Биелэлт-97%/	27	
	154	3. Журмын төслийг батлуулахаар ЗГ-т хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмын төслийг ЗГ-т хүргүүлсэн байна. Хугацаа: Хагас жилд	Хугацаа болоогүй		
86	155	4.1.6. “Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8-т заасан “газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг нийтээр дагаж мөрдөхөөр бүртгүүлнэ.” -Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг Хууль зүй, дотоод хэргийн яамаар бүртгүүлэх ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмыг бүртгүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	Уул уурхайн сайд, БОНХАЖ-ийн /хуучин нэрээр/ сайдын хамтарсан тушаалаар баталсан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Журмыг бүртгүүлэхтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн дүгнэлтийн дагуу зөрчлийг арилган, холбогдох өөрчлөлтийг оруулан, шинэчлэн боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын хамтарсан тушаалаар батлуулахаар тушаалын төсөл, холбогдох бичиг баримтыг боловсруулаад байна. Мөн Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтын дагуу яамны вэб сайтад байршуулан олон нийтээс санал авсан ба “Нээлттэй нийгэм форум”-д хэлэлцүүлсэн. Мөн Хууль зүйн сайдын 2016 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу журмын нөлөөллийн шинжилгээг хийж байна. /Биелэлт-90%/	27	

87	156	4.1.7. “Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмыг боловсруулж, батлуулна. 1. Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмыг боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмын төслийг боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмын төсөл боловсруулсан бөгөөд Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн 62 дугаар зүйлд “... захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах...”-аар заасны дагуу хэлэлцүүлэг хийхээр ажиллаж байна. Журмын төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, гэрээлэгчүүдээс саналыг авч тусгахаар УУХҮЯамны www.mmhi.gov.mn сайтад төслийг байршуулж санал авч байна. /Биелэлт-70%/	27	
	157	2. Журмын төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, гэрээлэгчүүдээс саналыг авч тусган батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх арга хэмжээг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмын төсөлд санал авсан байна. Төслийг ХЗДХЯ-нд бүртгүүлэх арга хэмжээг авсан байна. Хугацаа: Жилдээ	Журмын төсөлд санал авч байна. 2018 онд үргэлжлэн хэрэгжинэ. /хугацаа болоогүй/	21	
88	158	4.1.8. “Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан “Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага” журмыг бүртгүүлнэ. “Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага” журмыг Хууль зүй, дотоод хэргийн яамаар бүртгүүлэх ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмыг бүртгүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	“Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан “Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага” журмыг боловсруулан бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж ирүүлэхээр буцаагдсан. -Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд Хууль зүйн сайдын 2016 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу нөлөөллийн шинжилгээ хийлгэж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудаснаа 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр байршуулан олон нийтээс саналыг авсан. Мөн “Нээлттэй нийгэм форум”-д хэлэлцүүлж, журмыг батлуулахаар дахин УУХҮ-ийн сайдын тушаалын төсөл боловсруулж, удирдлагуудад танилцуулж байна. /Биелэлт-100%/	21	
89	159	4.1.9. “Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах” журмыг боловсруулан бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод	“Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах” журмыг боловсруулан бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод	21	

		хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах” журмыг бүртгүүлнэ. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг Хууль зүй, дотоод хэргийн ямаар бүртгүүлэхээр дахин хүргүүлэх ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмыг бүртгүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	хэргийн яаманд хүргүүлсэн боловч, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж ирүүлэхээр буцаагдсан. Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд Хууль зүйн сайдын 2016 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу нөлөөллийн шинжилгээ хийлгэж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудаснаа 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр байршуулан олон нийтээс саналыг авсан. Мөн “Нээлттэй нийгэм форум”-д хэлэлцүүлж, журмыг батлуулахаар дахин УУХҮ-ийн сайдын тушаалын төсөл боловсруулж, удирдлагуудад танилцуулж байна. /Биелэлт-100%/		
4.2. Газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:					
103 -	182	4.2.13. Улсын болон компанийн нөөцийг бүрдүүлнэ. /ЗГҮАХ 2.17.4/ Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч компаниудтай хамтран компанийн нөөцийг 30-аас дээш хоногийн нөөц бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тоо хэмжээ: Тухай бүр, Чанар: Компанийн 30 хоногийн нөөц бүрдүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	-Монгол Улсын 2017 оны төсвийн тодотгол, 2018 төсвийн төсөлд тус тус Улсын нөөц бүрдүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх талаарх саналыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн боловч дэмжигдээгүй. -Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх талаар зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцэн, тус өдрийн 297 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судлан шийдвэрлэж улсын нөөцөд 94700 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний нөөц бүрдүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Сангийн сайдад даалгасан. Уг ажлын хүрээнд улсын нөөц бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн тооцоолол судалгааг танилцуулгын хамт 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/2348 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлээд байна. -Мөн Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 147 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компаниудын нөөцийг 81900 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнээс доошгүй байхаар тогтоосон. Энэ оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 41 хоног /113242.75 тонн/-ийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 72 /17332.1 тн/, Аи-92 болон Аи-95 автобензин 53 /52865.35 тонн/, дизелийн түлш 30 /41091.18 тонн/, ТС-1 онгоцны түлш 22 хоног /1954.12 тн/-ийн нөөцтэй байгаа нь дээрх тогтоолын хэрэгжилтийг хангаж байна.	30	

			-Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 297 дугаар тогтоолоор 2018 онд бүрдүүлэх компанийн нөөцийн хэмжээг 94700 тонн байхаар тогтоосон. Тогтоолын хавсралтаар батлагдсан компанийн нөөц бүрдүүлэх үүрэг бүхий 21 компанитай 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор гэрээ байгуулан хэрэгжилтийн хангаж ажиллах чиглэлийг АМГТГ-т 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 03/2321 тоот албан бичгээр хүргүүлээд байна. /Биелэлт-100%/		
-	4.2.15. Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний нөхцөлийг сайжруулах, шатахууны үнийг олон улсын биржийн үнэтэй уялдуулан зохицуулах /ЗГҮАХ 2.17.2/ Роснефть болон Чайна Ойл компаниудаас нийлүүлж буй шатахууны худалдааны гэрээний нөхцөлийг сайжруулах	Тус яамны удирдлага болон холбогдох төлөөллийн хамт 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр ОХУ-ын Москва хотноо Роснефть компанийн төлөөлөлтэй, 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо Чайна Ойл компанийн төлөөлөлтэй тус тус “Монгол Улсад 2017 онд нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний үнэ, хангамжийн талаар санал тавих, цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцах” зэрэг асуудлуудаар уулзалтуудыг зохион байгуулж ажиллав. ОХУ-ын Роснефть компанийн төлөөлөлтэй шатахууны импортын үнийн хөнгөлөлт үзүүлэх, мөн евро-5 стандартын шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зэрэг асуудлаар санал тавьсан. Роснефть компанийн зүгээс Монгол улсыг газрын тосны бүтээгдэхүүнээр тасралтгүй, найдвартай хангахаа илэрхийлэн, шатахууны импортын үнийн хөнгөлөлт үзүүлэх, евро-5 стандартын шатахууны импортын хэмжээг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудаар холбогдох тооцоо судалгааг хийсний үндсэн дээр гарц, шийдэл олно гэдгээ илэрхийлсэн. БНХАУ-ын Чайна Ойл компанийн төлөөлөлтэй “Чайна Ойл” компанитай байгуулсан гэрээний нөхцөлийг сайжруулах арга зам, импортын үнийн томьёололд өөрчлөлт оруулах боломж, Замын-Үүдээс бусад боомтуудаар бүтээгдэхүүн импортлох боломж зэрэг асуудлаар санал тавьсан. Уулзалт хэлэлцээрийн үр дүнд Монголын импортлогч компаниуд 2017 оны 04, 05, 06 дугаар саруудад евро-5 стандартын РОН-93 болон дизелийн түлшийг спот гэрээний дагуу Роснефть компаниас нийлүүлж буй үнэтэй өрсөлдөхүйц үнээр худалдан авахаар тохиролцсон ба 2017 оны 07 дугаар сараас эхлэн урт хугацааны гэрээ байгуулан хамтран ажиллахаар зарчмын хувьд тохиролцсон. Ингэснээр өмнө нь тус компаниас авч байсан үнэ тооцох томьёоллоор тооцсон үнээс тонн тутамдаа 80 орчим ам.доллараар буурсан болно. Мөн ОХУ-ын Роснефть, БНХАУ-ын Чайна ойл компаниуд болон газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүд хооронд байгуулсан	30		

			гэрээний дагуу 2018 оны захиалгын хэмжээг баталгаажуулахдаа Евро-5 стандартын жишигт нийцсэн /Үндэсний стандартын K5 ангилал/ автобензин, дизель түлшний хэмжээг нэмэгдүүлэх талаар анхаарч, холбогдох арга хэмжээг авч ажиллах чиглэлийг АМГТГ-т 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 03/2551 тоот албан бичгээр хүргүүлээд байна. /Биелэлт-100%/		
4.3. Био болон эко, альтернатив түлшний үйлдвэрлэл, түлшний чанар стандарт, агаарын бохирдлыг бууруулах бодлогыг төлөвлөх, боловсруулах, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:					
108	190	4.3.4. Био болон эко, альтернатив түлшний үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогын зохицуулалт хийх 1.Хийн хангамжийг хөгжүүлэх бусад эх үүсвэр, боломжийг судлаж удирдлагад танилцуулна. Тоо хэмжээ: 1. Чанар: Хийн хангамжийг хөгжүүлэх бусад эх үүсвэр, боломжийг судлаж удирдлагад танилцуулсан байна. Хугацаа: Жилдээ	-АМГТГ-аас шингэрүүлсэн шатдаг хийн импорт болон авто машин хийгээр цэнэглэх станцуудын байршлын судалгааг гаргуулан алан хэрэгцээнд ашиглаж байна. Уг судалгаа болон Шингэрүүлсэн шатдаг хийн аж ахуйн эрхлэгчдийн холбоо ТББ –ын санал хүсэлтэд үндэслэн АМГТГ, Барилгын хөгжлийн төв, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, МХЕГ-т авто машин хийгээр цэнэглэх станцын үйл ажиллагааг стандарт норм дүрэмд нийцүүлэх талаар албан бичиг илгээсэн бөгөөд уг асуудлаар холбогдох газруудаас хариу ирүүлсэн байна. -Байгалийн шингэрүүлсэн хийн түлшний агуулах сав, түгээх станцыг барьж байгуулан БНХАУ, ОХУ-аас байгалийн хий импортлон нийтийн тээврийн хэрэгслийг хийгээр хангах зорилго бүхий төсөл хэрэгжүүлэгч “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК –тай хамтран ажиллахаар эхний удаагийн уулзалтыг зохион байгуулж, бодлогын удирдамжаар ханган ажиллаж байна. /Биелэлт-90%/	27	
	191	2. Төрийн болон төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, төсөл, санаачилгыг бодлогоор дэмжинэ. Тоо хэмжээ: 1, Чанар: Холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна Хугацаа: Жилдээ	-ЭХС-ын 2017 оны 06 дугаар сарын 23 –ны өдрийн 23 тоот тушаалаар батлагдсан Нүүрснээс байгалийн синтетик хий гарган авах үйлдвэр, Улаанбаатар хотын хийн хангамжийн мастер төлөвлөгөө, техник эдийн засгийн урьдчилсан судалгааны чиглэлээр хамтран ажиллах үүрэг бүхий Ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж 2 удаа хуралдан төслийн хураангуйтай танилцаж, УУХҮЯ мөн энэ чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа тул түүнтэй хэрхэн уялдах зэрэгт тодруулга авч санал өгөв. Төслийг Сингапур улсын Poh Golden Ger Resources PTE /PGGR/ хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх төслийн анхны танилцуулга хийгдсэн бөгөөд уг төсөл нь ЭХЯ–ны ШУТЗ–өөр хэлэлцүүлэгдсэнээр 2017 оноос төслий бүтээн байгуулалтын ажил эхлэх төлөвлөгөөтэй байгаа. -УУХҮЯ болон Япон Улсын “Хийн нийгэмлэг”-ийн хамтран зохион байгуулсан “Нүүрснээс синтетик байгалийн хий гарган авах” төсөл болон “Японы хийн хэрэглээний тухай” танилцуулгыг хэлэлцэв.	27	

			/Биелэлт-90%/		
109	192	4.3.5. “Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ” /ЗГҮАХ 4.1.6/ Улаанбаатар хот болон томоохон суурин газруудад 2017 оноос шатахууны чанарыг Евро-5 стандартад шилжүүлэх ажлын бэлтгэлийг хангаж, үе шаттайгаар зохион байгуулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Бэлтгэл ажил хангагдсан байна. Хугацаа: Жилдээ	Улаанбаатар хот болон томоохон суурин газруудад 2017 оноос шатахууны чанарыг Евро-5 стандартад шилжүүлэх ажлын хүрээнд автобензин, дизель түлшний Евро-5 стандартын жишигт нийцсэн MNS стандартын төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, Стандартчиллын Үндэсний хорооны 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр боловсруулах Ажлын хэсэгт ажиллаж, Евро-5 стандартын шатахуун болон хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилтыг тусгуулсан. Евро-5 стандартын шатахууныг хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлэх, борлуулалтын үнийг ард иргэдэд санхүүгийн хүндрэл багатайгаар шийдвэрлэх асуудлыг “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн зургадугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаас Евро-5 стандартын чанарын шаардлага хангасан шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх, үнийг ялгавартай тогтоох, цаашид автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг чанар, стандарттай уялдуулан тогтоох хууль, эрхзүйн орчинг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам болон шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд даалгасан зөвлөмж гаргасан. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн холбогдох заалтууд болон “Зөвлөмж”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд Евро-5 стандартад нийцсэн автобензин, дизель түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, чанарын шаардлага хангахгүй байгаа автобензин, дизель түлшний импорт, борлуулалт, үйлдвэрлэлийг хязгаарлах, онцгой албан татварыг шатахууны чанар, стандарттай уялдуулан тогтоох зорилгоор Онцгой албан татварын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлалыг боловсруулсан ба Сангийн яаманд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна	27	
			/Биелэлт-100%/		
110	193	4.3.6. Автобензин, дизель түлш, шингэрүүлсэн шатдаг хий зэрэг түлш, шатахууны стандартыг боловсруулна.	Автобензин, дизель түлшний Евро-5 стандартын жишигт нийцсэн MNS стандартын төсөл боловсруулж Стандартчиллын Үндэсний хорооны 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулаад байна.	15	

		Агаарын тухай хууль. /2012-05-17/. 17.2.4 1.Автобензин, дизель түлш, шингэрүүлсэн шатдаг хийн Евро-5 болон олон улсын стандартын жишигт хүрсэн Үндэсний стандартын төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж батлуулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Төсөл боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	Мөн Шингэрүүлсэн шатдаг хийн талаарх АНУ-ын NFPA-58 стандартын орчуулгад тулгуурлан Монгол орны цаг уур, ахуй, соёлын онцлогт тохирсон Үндэсний стандартын төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. /Биелэлт-100%/		
194		2.Экспортод гаргаж буй нүүрс нүүрсэн бүтээгдэхүүний стандартад нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын хэсэг байгуулах, төсөл боловсруулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Ажлын хэсэг байгуулсан байна. Хугацаа: Жилдээ	“Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний стандарт MNS 6457-2014” –т нэмэлт өөрчлөлт оруулан, батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 01 дугаар сарын 18–ны өдрийн А/46 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг чиг үүргийн хүрээнд 4 удаа хуралдаж стандартын төслийг хэлэлцэн боловсруулсан Мөн 2014 оноос хойш гаалийн хяналтад хамрагдсан дээжүүдээр хураангуй судалгаа гаргаж төсөл боловсруулахад ашигласан. -Төсөлд АМГТГ, Гаалийн төв лаборатори, Онцгой байдлын ерөнхий газар, Геологийн төв лаборатори, Уул уурхайн хүрээлэн болон нүүрс экспортлогч аж ахуйн нэгжүүдээс 2017оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 03/2322 тоот албан бичгээр санал авч саналын товъёог гаргасан. Ирүүлсэн саналын хүрээнд холбогдох засвар өөрчлөлтийг хийж, СХЗГ-ын Стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэхээр 2017 оны 12 дугаар сарын 04 –ний өдрийн 07/2553 тоот албан бичгээр төслийг хүргүүлсэн. /Биелэлт-100%/	27	
195		3.Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний төв лабораторийн барилгын асуудлыг шийдвэрлүүлэх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, хэлэлцүүлнэ. Тоо хэмжээ: 1 Чанар: Тогтоолын төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	АМГТГ–ын Уул уурхайн шинжилгээний төв лабораторийн барилгын асуудлыг шийдвэрлүүлэхээр Засгийн газрын 2015 оны 408 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лабораторийн барилгыг буцаан шилжүүлэхээр 2016 оны 08 дугаар сарын 17–ны өдрийн 40 дүгээр тогтоолын 2.3, 2.4 дэх заалтыг өөрчлөх тухай ЗГ–ын тогтоолын төслүүдийг боловсруулан 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01/71, 01/72 тоот албан бичгээр бүх яамдаас санал авч, саналын товъёог бэлтгэсэн. Уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл, танилцуулга болон холбогдох материалыг бүрдүүлэн 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ЗГХЭГ-т албан бичгээр хүргүүлсэн. Энэ хүрээнд 2017 оны 01 дүгээр сарын 18, 25–ны өдрүүдийн	27	

			Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд уг хуралдаанаас Ажлын хэсэг байгуулан тухайн барилга байгууламжуудыг газар дээр очиж үнэлэлт, дүгнэлт өгч эцсийн шийдвэр гаргахыг ЗГХЭГ-т үүрэг болгосон. Уул уурхайн шинжилгээний лабораторийг газрын тосны чанар хяналтын лабораторийн барилгад нүүлгэн шилжүүлснээр үйл ажиллагаа жигдэрсэн. /Биелэлт-100%/		
	196	4.Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний төв лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх бодлого зохицуулалт хийнэ. Тоо хэмжээ: 1, Чанар:Лабораториудын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна. Хугацаа: Жилдээ	4. Уул уурхайн шинжилгээний төв лабораторийг Хан-Уул дүүрэгт орших байрнаас АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лабораторийн барилгад нүүлгэн шилжүүлсэн. Хоёр лабораторийг нэгтгэж байгаатай холбоотойгоор нэгдсэн лабораторийн нэршлийг УУХҮ-ийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/120 дугаар тушаалаар “Уул уурхай, газрын тосны төв лаборатори” болгон өөрчилсөн. /Биелэлт-100%/	30	
5.0 ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХУВИЛБАР БОЛОВСРУУЛАХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:					
5.3. Газрын тос, уламжлалт бус газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрсийг хагас, гүн боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр байгуулах, бүтээгдэхүүнийг дотоод, гадаад зах зээлд борлуулах бодлогын удирдамжаар хангах					
127	220	5.3.4.Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулна. /ЗГҮАХ-2.70.3/ 1.Барилгын ажлыг гүйцэтгэх бэлтгэлийг хангана. Тоо хэмжээ: 1, Барилгын ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан геологи, геодези, хөрсний судалгааны ажлыг эхлүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй БНЭУ-ын EIL компаниболон түүний туслан гүйцэтгэгч "Престиж инженеринг" ХХК нь газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн байрзүйн зураглал, инженер-геологийн судалгааны ажлуудыг 2017 оны 11 дүгээр 10-ны өдрөөс эхлэн орон нутагт эхлүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2017оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн А/208 тоот тушаалаар байгуулагдсан газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардагдах дэд бүтэц, байршлын мэдээ, мэдээлэл холбогдох тоо баримтаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг орон нутгаас шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна. /Биелэлт-100%/	30	
6.0. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОХИЦУУЛАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:					
6.1. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах гол зорилтын хүрээнд:					
133	227	6.1.1.Салбарын холбогдох хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах,	Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Алт-2” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний	27	

		хэрэгжилтэд санал дүгнэлт боловсруулна. 1.Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: Тухай бүр, Чанар: Тодорхой ажил зохион байгуулсан байна. Хугацаа: Жилдээ	дагуу бичил уурхайн асуудлаар ГБГ-тай мөн алтны олоборлолт болон борлуулалтын мэдээг АМГТГ-аас авч ажиллаж байна. /Биелсэн-100%/		
134	228	6.1.2 Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбогдуулан дагаж мөрдөх журам, гэрээний загварыг батлуулна. 1. Ашигт малтмалын баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх журам боловсруулах, батлуулна Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ	УУХҮСайдын 2017 оны 6-р сарын 30-ны өдрийн “Ашигт малтмалын баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх журам” боловсруулж батлуулах ажлын хэсэгт тус газраас орж ажиллаж, 2017 оны 10-р сарын 17-25-ны өдрүүдэд БНХАУ-ын Бээжин, Янтай, Ухань хотод томилолтоор ажиллаж баяжуулах үйлдвэрийн туршилт судалгаа, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, барилгын ажил гүйцэтгэдэг БГРИМ, Синьхай, Жинпень компаниуд, тэсэлгээ, машины үйлдвэрлэл эрхэлдэг Норинко группын үйл ажиллагаатай газар дээр нь танилцсан. /Биелэлт-80%/	15	
108		4. Хуулийн төслийг Эрдэс баялгийн бодлогын зөвлөл, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын саналыг тусгах, хэлэлцүүлэг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Эрдэс баялгийн бодлогын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын саналыг тусгана. Хугацаа: 1-р улирал	-Уул уурхайн тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн гишүүдийн хамт Эрдэнэт үйлдвэр ХХК-д томилолтоор ажиллаж Уул уурхайн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж 2017 оны 1-р сарын 7-11-ний өдрүүдэд ажилласан. -Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 9.5-д “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах явцад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдээс санал авч, төсөл боловсруулахад харгалзан үзнэ” гэж заасны дагуу хуулийн төслийг дараах байгууллага, аж ахуйн нэгжүүдэд танилцуулж санал авч саналыг хуулийн төсөлд тусгах ажлыг гүйцэтгэж байна. Үүнд: Уурхай, үйлдвэрийн байршил дээр: - “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн удирдлага, инженер техникийн ажилтнууд - Улаанбаатар хотод: - Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Ажлын алба, Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институт, Ашигт малтмал ил аргаар олборлогчдын технологийн инженерүүдийн холбоо, Уул уурхайн хүрээлэн, Маркшейдерийн холбоо, Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбоо, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, Монголын уул уурхайн зураг төсөл зохиогчдын холбоо, Монголын экспортлогчдын холбоо, Монголын төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбоо, Канадын СЕСМИМ төсөл зэрэг уул уурхайн салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагын төлөөлөл - ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн Уул уурхайн салбарын багш, эрдэмтэн, доктор, профессорууд - Монгол Нүүрс ассоциаци, түүний гишүүн байгууллагууд болох “Энержи Ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Саус гоби сэндс” ХХК, “Шарынгол” ХК, “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК зэрэг нүүрсний олборлолт хийдэг компаниуд	28	

			-Нээлттэй нийгэм форумас зохион байгуулсан иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан 2 удаагийн уулзалт хэлэлцүүлэг -Канадын ЭСЯ-аас зохион байгуулсан Канадын ЭСЯ, АНУ-ын ЭСЯ, Австралийн ЭСЯ, Английн ЭСЯ, Оолон улсын валютын сан, БНСУ-ын Койка, Миреко, Канадын Мерит төсөл, Сесмим төсөл, Швейцарийн холбооны улсын Тогтвортой бичил уурхай төсөл зэрэг донор орнуудын ЭСЯ, байгууллагуудад Уул уурхайн тухай хуулийн төслийг танилцуулах танилцуулга, Мөн яамны веб сайт дээр Уул уурхайн тухай хуулийн төсөл, Уул уурхайн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг тавьсан. -Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого, Уурхайн хаалтын журам” сэдэвт уулзалт семинарт Уул уурхайн тухай хуулийн төслийн талаар танилцуулга хийсэн. -Геологийн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөлд Уул уурхайн тухай хуулийн төслийн талаар танилцуулга хийсэн. /Биелэлт 100%/		
	109	5. Хуулийн төсөлд яамдын саналыг тусган боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. Хугацаа: 1-р улирал	Хугацаа болоогүй	40	
60	110	3.1.2. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлнэ. /ЗГҮАХ-2.67.2/ 1. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр эрх зүйн орчинг бүрдүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. Хугацаа: 1-р улирал	“Уул уурхайн тухай хууль”-ийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцээд ЗГҮАХ-т тусгасан зорилтыг хангах зорилгоор “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын төслийг ойрын хугацаанд боловсруулан батлуулахаар төлөвлөж дэд ажлын хэсгийг байгуулан журмын төслийг боловсруулсан. “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын төсөл боловсруулах Дэд ажлын хэсгийг УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ болон судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж, журмын төслийн талаар санал солилцсон. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийж, вэб сайтад төслийг байршуулан олон нийтийн саналыг авч байна. Журмын төсөлд санал авахаар БОАЖЯ руу 05 дугаар сарын 22-ны өдөр 01/1166 албан тоотоор хүргүүлээд байна.	36	

			/Биелэлт 90%/		
61	111	3.1.3. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна. /ЗГҮАХ-2.65/ 1. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг баримт бичгийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулж, хөтөлбөрийн төслийг боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг олон салбарын оролцоог хангасан байдлаар зохион байгуулж, баримт бичгийн төслийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулсан байна. Хугацаа: 4-р улирал	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ТНБД-ийн 2017.10.09-ний өдрийн А/134 дугаар тушаалаар "Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг"-ийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан ба ажлын хэсгийн гишүүдээс мэдээлэл авч нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэж байна. 2017.11.29-ний өдрийн байдлаар Эрчим хүчний яам, Сангийн яам, Зам тээврийн хөгжлийн яам, хүнд үйлдвэрийн бодлогын газруудаас мэдээллийг авч нэгтгээд байна. /Биелэлт 90%/	36	
	112	2. Баримт бичгийн төслийг яам, агентлагийн цахим хуудсанд байршуулж, Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, зарим аж ахуйн нэгжүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдгээрээс гарсан саналыг тусган ЗГ хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Төслийг цахим хуудсанд байршуулж, хэлэлцүүлэг хийж саналыг тусгасан байна. Хугацаа: 4-р улирал.	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хангах зорилгоор холбогдох яам болох Эрчим хүчний яам, Зам тээвэр, хөгжлийн яамны төлөөлөлтэй 2017 оны 1 улиралд уулзалт зохион байгуулж санал солилцон холбогдох мэдээллийг солилцов. Мөн төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулж төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах судалгааны ажил хийгдэж байна. Судалгааны тайланг 12 дугаар сарын 25-нд багтаан удирдлагад танилцуулахаар ажиллаж байна. /Биелэлт-60%/	20	
	113	3. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хангах зорилгоор холбогдох яам болох Эрчим хүчний яам, Зам тээвэр, хөгжлийн яамны төлөөлөлтэй 2017 оны 1 улиралд уулзалт зохион байгуулж, санал солилцон холбогдох мэдээллийг солилцов.	40	28

		хангах, хамтран ажиллах механизм бүрдүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Батлагдсан баримт бичгийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллана. Хугацаа: 4-р улирал	/Биелэлт 100%/		
3.2. Ашигт малтмалын ордуудыг олборлох, баяжуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг зохицуулах болон ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:					
62	114	3.2.1. Тухайн үйлдвэрийн технологиор ашиглах боломжгүй овоолго, хаягдлын аж ахуйг эргүүлэн ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. /ЗГҮАХ-2.67.1/ 1. “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслийг боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмын төслийг хуульд нийцүүлэн боловсруулсан байна. Хугацаа: 1-р улирал	“Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам” болон “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор батлуулсан ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 дугаар тушаалаар журмын хэрэгжилтийг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. /Биелэлт – 100%/	40	
	115	2. “Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журмын төслийг хуульд нийцүүлэн боловсруулсан байна. Хугацаа: 1-р улирал	“Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам” болон “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор батлуулсан. /Биелэлт 100%/	40	
	116	3. Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам, Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам”-ын төсөлд яамдаас санал авч нэгтгэн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ. Тоо хэмжээ: 2 удаа, Чанар: Журмын төсөлд яамдын саналыг тусгасан	“Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам” болон “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор батлуулсан ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 дугаар тушаалаар журмын хэрэгжилтийг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор баталсан Үүсмэл орд ашиглахтай холбогдсон журмуудын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулахад оролцсон. "Ачит Ихт"	40	

		боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Хугацаа: 1-р улирал	ХХК-ийн Үүсмэл ордын нөөцийн тайланг ЭБМЗ-ийн 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргахад оролцож ажилласан /Биелэлт 100%/		
63	117	3.2.2. “Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулна. /ЗГҮАХ-2.69.8/ 1. “Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрмийг шинэчлэн боловсруулна Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Дүрмийн төслийг боловсруулсан байна. Хугацаа: 2-р улирал.	Алт агуулсан хүдэр, элс олборлон баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай холбогдсон журмын төслийг шинэчлэн боловсруулсан. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, хуульд заасны дагуу журмын төсөлд Нөлөөллийн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн Хуулийн хэлтэст хүргүүлэн хянуулсан. /Биелэлт 100%/	40	
	118	2. Үлгэрчилсэн дүрмийн төслийг яам, агентлагийн цахим хуудсанд байршуулж, ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдүүдийн саналыг тусган боловсруулж, холбогдох байгууллагатай хамтран батална. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж батлуулсан байна. Хугацаа: 2-р улирал	-Журмын төслийг яамны веб сайтад байршуулан олон нийтийн санал, зөвлөмжийг авч, улмаар СЯ, СХЗГ, ЦЕГ, Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооноос журмын төсөлд санал авч тусгасан. АМГТГ-тай хамтран алтны чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, уулзалтын үеэр алтны салбарт тулгамдаад байгаа асуудал, тэдгээрийг шийдвэрлэх нөхцөл боломжийн талаар санал солилцон шинээр боловсруулсан журмын төслийг танилцуулан хэлэлцүүлэг хийж тэдгээрээс гарсан саналыг журмын төсөлд тусгасан. -Журмын төслийг Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд хамтран баталж, Захиргааны актын бүртгэлд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. /Биелэлт 100%/	40	
64	119	3.2.4. “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулна. 1. “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар:Дүрмийн төслийг боловсруулсан байна. Хугацаа: 4-р улирал	-“Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар Холбогдох байгууллагууд /АМГТГ, Багануур, Шивээ-Овоо, Эрдэнэт, Оюутолгой/-тай санал солилцсон. УУХҮ-ийн Сайдын тушаалын төсөл боловсруулж байна. /Биелэлт-20%/	4	
	120	2. Дүрмийн төслийг яам, агентлагийн цахим хуудсанд байршуулах, Төрийн бус	Дүрмийн төсөл боловсруулагдаж дууссаны дараа уг ажил хийгдэнэ. /Дүгнэх боломжгүй/	/-/	

		байгууллага, мэргэжлийн холбоод, зарим аж ахуй нэгжүүдэд танилцуулан хэлэлцүүлэг хийж, саналыг тусган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Дүрмийн төслийг цахим хуудсанд байршуулан ирүүлсэн саналыг тусган ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Хугацаа: 4-р улирал			
65	121	3.2.5. “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг боловсруулна. 1. “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар:Дүрмийн төслийг боловсруулсан байна. Хугацаа: 4-р улирал	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 11-р сарын 22-ны өдрийн А/227 дугаар тушаалаар “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. /Биелэлт- 50%/	20	
	122	2. Дүрмийн төслийг яам, агентлагийн цахим хуудсанд байршуулж, дүрмийн төслийг Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, зарим аж ахуй нэгжүүдэд танилцуулан хэлэлцүүлэг хийж, саналыг тусган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Дүрмийн төслийг цахим хуудсанд байршуулан ирүүлсэн саналыг тусган ЗГХЭГ-т хүргүүлсэн байна Хугацаа: 4-р улирал	Дүрмийн төсөл боловсруулагдаж дууссаны дараа уг ажил хийгдэнэ. /Дүгнэх боломжгүй/	/-/	
66	123	3.2.6. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулна.	-УУХҮ-ийн сайдын 2017.04.17-ны өдрийн А/80 дугаар тушаалаар байгуулагдсан "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-	20	

		1. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Дүрмийн төслийг боловсруулсан байна. Хугацаа: 4-р улирал	ийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийн байгуулж, 10 гаруй удаа хуралдаж, дүрмийн төслийг боловсруулж одоогоор 90%-тай байна. -Тус ажлын хэсгийн гишүүд Оюутолгой, Тавантолгой зэрэг ордууд дээр Тэсэлгээний ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хуучин дүрмийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар газар дээр нь танилцах ажлыг зохион байгуулсан. /Биелэлт-90%/		
	124	2. Дүрмийн төслийг яам, агентлагийн цахим хуудсанд байршуулах, Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, зарим аж ахуй нэгжүүдэд танилцуулан хэлэлцүүлэг хийж, саналыг тусган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Дүрмийн төслийг цахим хуудсанд байршуулан ирүүлсэн саналыг тусган ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Хугацаа: 4-р улирал	Дүрмийн төсөл боловсруулагдаж дууссаны дараа уг ажил хийгдэнэ /Дүгнэх боломжгүй/	/-/	
3.3. Уул уурхайн салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалт, татвар, бүтээгдэхүүний худалдаа, экспортын бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:					
72	130	3.3.3. Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах оновчтой хувилбар боловсруулна. /ЗГҮАХ-1.24.1/, /ҮЧ-5.2/, /ЭЗСХ-2.2.1.1/ 1. Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах оновчтой хувилбарын төслийг боловсруулж төсөлд яамдын саналыг тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Иж бүрэн ашиглах оновчтой хувилбарын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн байна. Хугацаа: жилдээ	Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах ажлыг эрчимжүүлэх зорилгоор харьцуулсан судалгаа хийж, санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны А/67-р тушаалаар байгуулан Эрдэнэс Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК-тай хамтран орд ашиглах харьцуулсан тооцоо, судалгааг хийж Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглах боломжит хувилбарыг боловсруулан яамны удирдлага /Сайд/-д урьдчилсан байдлаар танилцуулаад байна. Мөн Энержи Ресурс компанийн Ухаа Худаг уурхайн 0-р давхаргын нүүрстэй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Цанхийн баруун хэсгийн 3, 4, 0-р давхаргын чанар муутай нүүрсийг хольж баяжуулан үр дүнг тодорхойлох үүргийг УУХҮ-ийн сайдаас Эрдэнэс Таван Толгой болон Энержи Ресурс компаниудад өгсний дагуу тус компаниуд анхдагч хэлэлцээрийг эхлүүлээд байна. -Монгол Улсын Уул уурхайн яам /хуучнаар/, Япон Улсын Шинэ эрчим хүч, аж үйлдвэрийн технологийн хөгжлийн байгууллага /NEDO/ хооронд 2016 оны 02 дугаар сард "Нүүрсний хуурай баяжуулалтын технологийг Монголд нутагшуулахад хамтран ажиллах талаар Харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулсан ба тус санамж бичгийн хүрээнд Тавантолгойн ордод	36	

		түшиглэн жилд 300 мян.тн нүүрсийг хуурай аргаар баяжуулах хүчин чадалтай загвар үйлдвэрийг байгуулах “Гүйцэтгэлийн гэрээ”-г Япон Улсын Нагата инженеринг болон Монголын “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хооронд байгуулж, холбогдох туршилт судалгааны, ажлыг хийж гүйцэтгэхээр тохиролцсон боловч 2017 оны 4-р сараас “Эрдэнэс Монгол” ХХК нь санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас уг төслийг хэрэгжүүлэх боломжгүйгээ илэрхийлсэн тул УУХҮЯ-наас “Энержи Ресурс” ХХК-д 2017 оны 5 дугаар сард санал тавьсны дагуу “Энержи Ресурс” ХХК төслийг судлан үзэж, хамтран хэрэгжүүлэх боломжтой талаар саналаа илэрхийлсэн тул Санамж бичигт дурдсан төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын нэр болон, ажлын графикийг өөрчлөх, төслийг хэрэгжүүлэх Нагата инженеринг компани болон “Энержи Ресурс” ХХК хооронд гүйцэтгэлийн гэрээг байгуулахаар холбогдох ажлууд хийгдэж байна. -УИХ-ын гишүүн Д.Гантулгаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаарх мэдээллийг боловсруулж хүргүүлсэн. -Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг” байгуулагдсан. Ажлын хэсэг Тавантолгойн ордод төсөл хэрэгжүүлэгч компанийн 51-ээс доошгүй хувийг Монголын тал эзэмших, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх компанийн 51 хувийг төрийн өмчит “Монголын төмөр зам” ХК эзэмшин төрийн оролцоо, хяналтыг хангах, тодорхой хугацааны дараа үлдсэн 49 хувийг төрийн өмчийн компанид үнэ төлбөргүй шилжүүлэх, Тавантолгойн ордоос олборлосон нүүрсийг боловсруулж, нэмүү өртөг шингээх замаар БНХАУ болон гуравдагч зах зээлд борлуулах бүтцийг тодорхойлох чиглэл баримталж, энэ талаар Тавантолгойн ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах талуудад тодорхой саналыг хүргүүлээд байна. /Биелэлт 100%/		
4.0. ТҮЛШ, ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХУВИЛБАР, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:				
4.1. Түлш, газрын тосны салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:				

81	145	4.1.1. “Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого”-ыг шинэчлэн боловсруулна. /ЗГҮАХ 2.63.1/ 1. Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого”-ыг төслийг шинэчлэн боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого”-ыг төсөл боловсруулсан байна. Хугацаа: Хагас жилд	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/101 –р тушаалаар “Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлогын баримт бичиг” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулж, Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг гаргаж, газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж байна. Уг ажлын хүрээнд АМГТГ-т Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг гаргах дэд ажлын хэсэг байгуулагдан ажилласан. /Биелэлт-100%/	28	
	146	2. Төсөлд яамд болон бусад гэрээлэгч, эрдэмтэн судлаач, төрийн бус байгууллагуудаас саналыг авч, төсөлд тусган хэлэлцүүлэг зохион байгуулж Засгийн газарт хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого”-ыг төсөлд санал авч ЗГ-ын хуралдаанд танилцуулсан байна. Хугацаа: Жилдээ 30 /сая.төг/	Ажлын хэсгийн хуралдааныг удаа дараа зохион байгуулж, чиг үүргийн дагуу төслийг эцэслэн боловсруулаад байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн бодлогын төслийн нөлөөллийн шинжилгээ, төлөвлөгөөний төсөл болон бусад мэдээлэл судалгааг боловсруулж байна. Мөн бодлогын төсөлд 2017 оны 11-р сарын 30-ны өдөр санал авахаар УУХҮЯ болон АМГТГ-ын цахим хуудаснаа байршуулсан. Хэлэлцүүлгийн 2017 оны 12-р сарын 05-ны өдөр АМГТГ дээр зохион байгуулаад байна. Хэлэлцүүлгээс гарсан саналыг бодлогын төсөлд тусгаж, саналын товчоог бэлтгэж байна. /Биелэлт-85%/	28	
90	160	4.1.10. “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийг шинэчлэн найруулна. /ЗГҮАХ 2.17.1/ 1.“Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулж, ЗГ-т хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Ажлын хэсэг байгуулсан байна. Хугацаа: 1 дүгээр улирал	-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулах, төслийг боловсруулах, хянах, эцэслэн боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангах, үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Уг Ажлын хэсгийн хуралдаанаар асуудлыг хэлэлцэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулах санал, хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж ирүүлэх үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг хамруулсан өргөн бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсэг байгуулах чиглэлийг 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03/318 тоот албан бичгээр Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн. -Үүний дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн а/45 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн	36	

			төсөлд оруулах санал, хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсэг байгуулагдсан. -АМГТГ-ын 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 3/7615 тоот албан бичгээр Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулах саналыг урьдчилсан байдлаар ирүүлсэн. Цаашид дэд ажлын хэсгийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалгаа, хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн саналыг эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг буюу аж ахуйн нэгжүүд, мэргэжлийн холбоод болон харьяа байгууллагуудаас авч нэгтгэн, хуулийн төсөлд томъёолон тусгаж ирүүлэхээр ажиллаж байгаа болно. - Мөн Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслийн хүрээнд хийгдсэн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хийдэл, зөрчил, давхардалын судалгааг судлан тус ажлын хүрээнд 4 давхардал, 12 зөрчил, 7 хийдэлд санал дүгнэлтийг боловсруулав. Тус санал, дүгнэлтийг үндэслэн Газрын тосны бүтээгдэхүүний тухай болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналын томъёоллыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 02/2598 тоот албан бичгээр хүргүүлсэн. /Биелэлт-90%/		
4.2. Газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд:					
91	161	4.2.1. Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ. /ЗГҮАХ 2.63.3/ 1.Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг шинэчилсэн газрын тосны тухай хуульд нийцүүлэх талаар хэлэлцээрийг хийнэ. Тоо хэмжээ: 10, Чанар: Хэлэлцээр хийгдсэн байна. Хугацаа: Хагас жилд	-Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. -Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Газрын тосны тухай хууль батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн үндсэн нөхцөлийг өөрчлөхгүйгээр Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварт нийцүүлэн хэлэлцээр хийж шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг	36	

		УУХҮСайдын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/57 тоот тушаалаар байгуулагдсан. -Гэрээ шинэчлэх ажил дуусах шатандаа явж байна. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Газрын тосны хайгуулын Хөх нуур-ХVIII талбайд БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Эн пи ай” ХХК, газрын тосны хайгуулын Төхөм-Х хойд болон Цайдам-ХХVI талбайнуудад мөн БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Сансрын геологи хайгуул” ХХК-тай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж гэрээг шинэчлэх ажлыг БНХАУ-ын Бээжин хотод амжилттай хийж гүйцэтгэсэн. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Газрын тосны тухай хууль батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн үндсэн нөхцөлийг өөрчлөхгүйгээр Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварт нийцүүлэн хэлэлцээр хийж шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/57 тоот тушаалаар байгуулагдсан. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй компаниудын БХГ-г шинэчлэх талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Ажлын хэсэг шинэчлэгдэн байгуулагдсан талаарх мэдэгдэл, ажлын хэсгийн уулзалтыг 2016 оны 11 дүгээр сард багтаан зохион байгуулах саналаа 2016 оны 11 дугаар сарын 01-ний өдрийн 1/1351 тоот албан бичгээр “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д мэдэгдсэн. Тус компаниас 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 16/1-1506 тоот албан бичгээр “хөрөнгө оруулагч талын эдийн засгийн эрх ашиг болон эдийн засгийн үр ашгийг хохироохгүй байх” хүрээнд 11 дүгээр сард дараагийн шатны хэлэлцээрийг хийх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Мөн 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 16/1-1580 тоот албан бичгээр хэлэлцээрийг 2016 оны 12 дугаар сарын 14-16-ны өдрүүдийн хооронд хийх хүсэлтэй байгаагаа мэдэгдэж, хэлэлцээрт оролцох хүмүүсийн албан тушаал, нэрсийг компаниас ирүүлсэн. Бүтээгдэхүүн хуваах гэрээ шинэчлэх хэлэлцээрийг зохион байгуулахаар 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 1/1938 тоот, мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 03/1017 тоот, 2017 оны 7-р сарын 24-ны өдрийн 07/1636 тоот албан бичгээр хэлэлцээрийг Улаанбаатар хотноо зохион байгуулахыг удаа дараа мэдэгдэж байсан. Талуудын хооронд хийсэн уулзалт, тэмдэглэлийн		
--	--	--	--	--

		төслийг албажуулахаар эцсийн байдлаар 2017 оны 10-р сард Петрочайна Дачин Тамсаг ХХК-д хүргүүлээд байна. Доншен группийн ерөнхий захирал Ли Шан, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн ерөнхий захирал Сүн Юнчуань-тай 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр уулзаж, санал солилцсон. Уулзалтын үеэр тус компанийн зүгээс Бүтээгдэхүүн хуваах гэрээг Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан загварт нийцүүлэх ажлын хэсгийг 2017 оны 01 дүгээр сард багтаан байгуулж, АМГТГ-т мэдэгдэхээ илэрхийлсэн. Уулзалтын үр дүнд хоёр тал уулзалтаар тохиролцсон асуудлуудаар протокол байгуулсан. Хэлэлцээрийг 2 дугаар сард дахин зохион байгуулах саналыг Доншен газрын тос (Монгол) ХХК-д хүргүүлсэн боловч, хоёр улсын Сар шинийн баярууд ээлжлэн тохиож, хэлэлцээр хойшлогдсон. Хэлэлцээрийг 03 дугаар сард зохион байгуулах талаар дахин мэдэгдсэний дагуу Ажлын хэсэг 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцээр хийж, хоёр талын саналуудыг тусгасан тэмдэглэлд 2 талаас гарын үсэг зурсан. Ашиглалтын үе шатны гэрээлэгчид бүтээгдэхүүн хуваах гэрээг өөрчлөхгүй гэсэн байр суурьтай байна. УУХҮС-аас өгсөн чиглэлийн дагуу А/57 ажлын хэсгийн тушаалыг шинэчлэхээр төсөл боловсруулан Сайдад танилцуулж байна. Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй кампаниудын хувьд дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Хайгуулын үе шатны гэрээг шинэчлэх ажлын хэсэг 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хуралдуулж, ажлын хэсгийн гишүүдэд хариуцсан ажлын дагуу төлөвлөгөө гаргаж ажиллах, холбогдох мэргэжилтэнүүдэд БХГ тус бүрээр хэрэгжилтийг гаргах, санал дүгнэлт боловсруулах талаар үүрэг өгсөн болно. Тушаал батлагдснаас хойш 2017 оны 04 дүгээр сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 10 гэрээлэгчтэй уулзалт хэлэлцээр хийсэн болно. Үүнд: Нялга- XVI талбайн гэрээлэгч “Шэйман” ХХК, Борзон-VII талбайн гэрээлэгч “Импайр газ Монголиа” ХХК, Төхөм-Х урд талбайн гэрээлэгч “Монголын Алт” ХХК, Баян түмэн-XVII талбайн гэрээлэгч “Магнай трэйд” ХХК, Матад-XX талбайн гэрээлэгч “Петро Матад” ХХК, Онги-IV, Богд-V талбайд “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитэд” ХХК, Галба XI талбайн гэрээлэгч Зонг Хэн юу тиэн ХХК, Хөхнуур XVIII талайн гэрээлэгч “Эн Пи Ай” ХХК, Цайдам XXVI, Төхөм Х-хойд талбайнуудын гэрээлэгч “Сансарын геологи хайгуул” ХХК Сүхбаатар XXVII талбайн гэрээлэгч Вульф петролиум ХХК зэрэг 10 кампаниудын төлөөлөлтэй уулзаж БХГ-ний гэрээг шинэчлэх талаар хэлэлцэж уулзалтуудыг зохион байгуулсан болно.		
--	--	---	--	--

		Тушаал батлагдсанаас хойш 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 10 гэрээлэгчтэй 12 гэрээ шинэлэх асуудлаар уулзалт хэлэлцээр хийсэн. Хайгуулын үе шатанд хэрэгжиж буй шинэчлэх шаардлагатай нийт 15 Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдээс 4 гэрээг шинэчлэн байгуулсан, 3 гэрээг шинэчлэн байгуулахад бэлэн болгож, 3 гэрээг шинэчлэхээр хэлэлцээ хийж байна. Мөн 2 гэрээний гэрээлэгч гэрээт талбайнуудыг бүхэлд нь буцаах хүсэлтийг гаргаж гэрээг шинэчлэхээс татгалзаж, 2 гэрээний гэрээлэгч газрын тосны ашиглалт явуулах нь эдийн засгийн үр ашиггүй гэж үзсэн тул гэрээнүүдийг цуцлах тухай хүсэлт гаргасан, 1 гэрээ шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдэж гэрээг дүгнэх ажил үргэлжилж байна. Өнөөдрийн байдлаар: -Борзон-VII талбайн гэрээлэгч “Импайр газ Монголиа” ХХК, -Төхөм-Х урд талбайн гэрээлэгч “Монголын Алт” ХХК -Сүхбаатар XXVII талбайн гэрээлэгч “Вульф петролиум” ХХК Хөхнуур XVIII талайд “Эн Пи Ай” ХХК компаниудын гэрээг шинэчилсэн болно. /Биелэлт – 100%/		
162	2.Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг 2015 оны Засгийн газрын 104-р тогтоолоор батлагдсан загварт нийцүүлж, холбогдох төрийн байгууллагуудаас саналыг авч Засгийн газарт танилцуулна. Тоо хэмжээ: 5 удаа, Чанар: Холбогдох санал авсан байна. Хугацаа: Хагас жилд	Хайгуул, ашиглалтын шатны БХГ-нүүдийг шинэчилсэний дараа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. /Биелэлт – 95%/	20	
163	3. Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ 97 талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг Засгийн газрын 104-р тогтоолоор батлагдсан загварт нийцүүлэх талаар ҮАБЗ-д танилцуулна. Тоо хэмжээ: 5, Чанар: Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг шинэчилж ҮАБЗ-д танилцуулсан байна. Хугацаа: Хагас жилд	Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ 97 талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг Засгийн газрын 2015 оны 104-р тогтоолоор батлагдсан загварт нийцүүлэх талаар ҮАБЗ-д танилцуулахаар ажлын явцын талаар танилцуулга, холбогдох мэдээллийг боловсруулсан. /Биелэлт-100%/	36	
164	4. Гэрээлэгчийн татварын хувь хэмжээг тогтворжуулах “Хөрөнгө оруулалтын	Газрын тосны ашиглалтын эхний 10 жилд НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөхөөр тус хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах саналын томъёоллыг бэлтгэж, Хуул зүй, дотоод хэргийн яаманд Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд	36	

		гэрээ”, “тогтворжуулалтын гэрчилгээ” авахад бодлогын дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: 5, Чанар: Бодлогын дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: Хагас жилд	сайдын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 02/2598 тоот албан бичгээр хүргүүлсэн. Ашигт малтмал, газрын тосны газраас татварын буцаан олголттой холбоотой асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүссэн албан тоотыг 2017 оны 10-р сарын 04-ний өдөр Татварын ерөнхий газрын дэргэдэх татварын маргаан таслах зөвлөлд хүргүүлсэн. /Биелэлт-100%/		
92	165	4.2.2. Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 2.63.4/ 1. Газрын тосны Тосон-Уул XIX, Тамсаг XXI, талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, БХГ 97 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Доншен газрын тос” Монгол ХХК-уудын үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана. Тоо хэмжээ: -, Чанар: Бодлогын дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: Хагас жилд	-Газрын тосны Тосон-Уул XIX, Тамсаг XXI, талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, БХГ 97 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Доншен газрын тос” Монгол ХХК-уудын үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллаж байна. -Тус компаниуд 2017 онд Тосон–Уул XIX талбайд 210.0 сая ам.доллар, Тамсаг XXI талбайд 231.0 сая ам.доллар, БХГ-97 талбайд 11.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт тус тус хийж, 1.1 сая тонн газрын тос олборлон экспортолж, улсын төсөвт онд 8.1 сая баррель /1.1 сая тонн/ газрын тос олборлон экспортолж, “2017 оны төсвийн тухай” хуулиар борлуулалтын орлогоос улсын төсөвт 191,8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэх үүрэгтэй. Энэ оны 11 дүгээр сарын 29-ний байдлаар нийт 6.99 сая баррель /949 мянган тонн/ газрын тос олборлон 6.92 сая баррель /941 мянган тонн/, газрын тосыг экспортолж, улсын төсөвт 178.7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэн экспорт 85.3 %, төсвийн орлого 93.1 %-ийн гүйцэтгэлтэй байна. -Хүлээгдэж буй гүйцэтгэлээр газрын тос олборлолт 7,7 сая баррель буюу төлөвлөгөө 95,1 % биелэхээр байна. 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд: <u>Тосон-Уул XIX талбайд:</u> - Газрын тосны ашиглалтын 87 цооног өрөмдөхөөр төлөвлөснөөс 60 цооног өрөмдөөд байна. - 4000 метрт перфораци, 94 цооногийн 206 үед шингэн хагалбарын ажил хийхээр төлөвлөснөөс 2751 метрт перфораци, 68 цооногийн 134 үед шингэн хагалбар хийгээд байна. - 71 цооногт олборлолтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, 44 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, 10 цооногт их засвар хийх, 10 цооногт полимер шахах, 13 төрлийн судалгаа хийхээр төлөвлөснөөс 30 цооногт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулж, 14 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж	40	

			суурилуулж, 6 цооногт их засвар хийж, 9 цооногт гел, полимер шахаж байна. - 197 цооногт гүний тоног төхөөрөмж суурилуулах, шалгах, засварлах ажил хийхээр төлөвлөснөөс 110 цооногт засвар үйлчилгээний ажил хийж гүйцэтгэсэн. - Урсгалын цахилгаан соронзон каротажийг 36 удаа, хүчилтөрөгчөөр идэвхжүүлсэн каротажийг 61 удаа, тэнхлэгийн дагуу үүссэн усны агууламжийн хэмжилтийг 67 удаа, бэхэлгээний яндангийн холбоосны байршлыг тодорхойлох соронзон каротажийг 33 удаа, цооногийн хазайлтын хэмжилтийг 6 цооногт, бүсчилсэн урсгалын хэмжилтийг 79 үед, тусгаарласан интервалыг тодорхойлох судалгааг 65 үед, усны цоргыг сугалах, суурилуулах судалгааг 72 үед, шахалтын байдлыг шалгах судалгааг 44 удаа хийж гүйцэтгэсэн. <u>Тамсаг XXI талбайд:</u> - Газрын тосны ашиглалтын 60 цооног өрөмдөхөөр төлөвлөснөөс 45 цооног өрөмдөөд байна. - 3000 метрт перфораци, 72 цооногийн 160 үед шингэн хагалбарын ажил хийхээр төлөвлөснөөс 2028 метрт перфораци, 57 цооногийн 101 үед шингэн хагалбар хийгээд байна. - 88 цооногт олборлолтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, 34 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, 11 цооногт их засвар хийх, 12 төрлийн судалгаа хийхээр төлөвлөснөөс 41 цооногт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулж, 15 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж суурилуулж, 11 цооногт их засвар хийгээд байна. - Урсгалын цахилгаан соронзон каротажийг 33 удаа, хүчилтөрөгчөөр идэвхжүүлсэн каротажийг 82 удаа, тэнхлэгийн дагуу үүссэн усны агууламжийн хэмжилтийг 98 удаа, бэхэлгээний яндангийн холбоосны байршлыг тодорхойлох соронзон каротажийг 47 удаа, цооногийн хазайлтын хэмжилтийг 5 цооногт, бүсчилсэн урсгалын хэмжилтийг 90 үед, тусгаарласан интервалыг тодорхойлох судалгааг 47 үед, усны цоргыг сугалах, суурилуулах судалгааг 54 үед, шахалтын байдлыг шалгах судалгааг 117 удаа хийж гүйцэтгэсэн. <u>БХГ-97 талбайд:</u> - 375 метрт перфораци хийхээр төлөвлөснөөс 157,2 метрт перфораци хийгээд байна.		
--	--	--	--	--	--

		- 8 цооног ус шахалтад шилжүүлэх, 5 хуучин цооногийг сэргээн олборлолтод шилжүүлэх, 8 цооногт ус шахалтын хэмжилт, тохиргоо, 20 цооногт олборлолтын яндан, сүмбэ солихоор төлөвлөснөөс 5 цооног ус шахалтад шилжүүлж, 5 цооног сэргээн олборлолтод шилжүүлж, 7 цооногт ус шахалтын хэмжилт, тохируулга хийж, 10 цооногт олборлолтын яндан, сүмбэ солих ажил хийгээд байна. Чойбалсангийн ДЦС-аас Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад нийлүүлж байгаа эрчим хүч нь хязгаарлагдмал, ордуудын нийт хэрэгцээг хангаж чадахгүй байгаа тул эрчим хүчний нөөц эх үүсвэр бий болгох зорилгоор БНХАУ-аас эрчим хүчний нөөцийн шугам татах асуудлаар Эрчим хүчний яаманд 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр албан бичиг хүргүүлээд байна. Мөн Тамсаг XXI талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн “Та-21 талбайн 2016 оны олборлолт нэмэгдүүлэх байгууламж” төслийн хүрээнд олборлолт нэмэгдүүлэх 49ш тосны цооногийн байгууламж, 18ш усны цооногийн байгууламж, 4ш ачилтын хэсгийн хоолойн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг тус тус Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/43 дугаар тушаалаар олгож, ажлыг эхлүүлээд байна. /Биелэлт-100%/		
166	2.Гэрээлэгч компаниудын гадаадаас авах ажиллах хүчний асуудлаар дэмжлэг үзүүлж, холбогдох төрийн байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлнэ Тоо хэмжээ: -, Чанар: Ажиллах хүчний асуудлаар дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: Хагас жилд	-Газрын тосны Тосон-Уул XIX, Тамсаг XXI, талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, БХГ 97 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Доншен газрын тос” Монгол ХХК-уудын үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллаж байна. Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 778, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 45, нийт 823 гадаад ажиллах хүч, мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлүүлсэн. Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 941, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 45, нийт 986 гадаад ажиллах хүч, мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд уламжилж, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 778, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 45, нийт 823 гадаад ажиллах хүч, мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлүүлсэн.	40	

		-Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн нэмэлт 176 гадаад ажиллах хүчний асуудлыг шийдүүлэхээр дэмжлэг хүсч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хандаж уг асуудлыг шийдвэрлүүлүүлсэн. -Мөн 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг сунгуулахаар хүсэлт гаргасан 820 гадаад иргэдийн материалыг судалж үзээд, 2018 оны ажлын төлөвлөгөө батлагдсаны дараа шийдвэрлэх боломжтой 65, Монгол иргэд хийх боломжтой 31, Монгол улсын мэргэшсэн жолоочийн үнэмлэхгүй 16 буюу нийт 112 гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг сунгах шаардлагагүй гэж үзэн хасч, 708 гадаад иргэд, “Доншен газрын тос” (Монгол) ХХК-ийн нарийн мэргэжлийн 68 гадаад мэргэшсэн инженер, техникийн гадаад ажиллах хүч, мэргэжилтнүүдийн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг сунгуулах хүсэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт УУХҮ-ийн сайдаас 01/25868 01/2585 тоот албан бичгээр тус тус хүргүүлээд байна. /Биелэлт-100%/		
167	3.“Петрочайна дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос” Монгол ХХК-уудын 2011-2013 онуудад хийсэн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардалд санхүүгийн хяналт, шалгалт хийхэд оролцоно. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Санхүүгийн шалгалт хийхэд оролцсон байх. Хугацаа: Хагас жилд	“Петрочайна дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос” Монгол ХХК-иудын 2011-2013 онуудад хийсэн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардалд санхүүгийн хяналт, шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсэг АМГТГ-ын даргын өдрийн а/36 дугаар тушаалаар байгуулагдан ажилласан. -Тосон-Уул XIX талбайд 2012 онд зардлыг 855837 ам.доллараар, 2013 онд 25488810 ам.доллараар, шингэн хагалбар, перфорацийн ажлуудын зардлыг 24025474 ам.доллараар, цооногийн хэмжилт туршилтын ажлын зардлыг 1125962 ам.доллараар, Тамсаг ХХI талбайд 2013 онд зардлыг 8347674 ам.доллараар, шингэн хагалбар, перфорацийн ажлуудын зардлыг 12822094.75 ам.доллараар, цооногийн хэмжилт туршилтын ажлын зардлыг 61904 ам.доллараар урьдчилсан байдлаар гэрээлэгчтэй тохиролцоод байна. БХГ-97 талбайд үйл ажиллагаа явуулж буй Доншен газрын тос Монгол ХХК-ийн 2012, 2013 оны өрөмдлөг, шаврын судалгааны ажилд зарцуулсан зардлыг шалгаж дараах санал дүгнэлтийг гаргасан. Үүнд: - 2012 онд 10 цооног өрөмдсөн бөгөөд өрөмдлөгийн ажилд 6088803.81 ам.доллар, 2013 онд 5 цооног өрөмдсөн бөгөөд өрөмдлөгийн ажилд 3419080.38 ам.доллар зарцуулсныг судалж үзээд дараах саналыг гаргаж, баталгаажуулсан. - 2012 оны 1 дүгээр сарын 12-нд байгуулсан санамж бичгийн 3-т өрөмдлөгийн ажлын нэгж үнийг 2560 юань байсныг 68 юаниар нэмж 2628	40	

		юань болгосон тухай тусгагдсан байна. Тиймээс гэрээлэгчийн өртөг нөхөх зардлын тайланд тусгагдсан зардал нь туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнэд багтаж байгаа тул өрөмдлөгийн ажилд зарцуулсан 6086483.04 ам.долларыг өртөг нөхөх зардлаар баталгаажуулах, - Өрөмдлөгийн ажлын туслан гүйцэтгэгчтэй байгуулсан 2013 оны гэрээний нэгж үнэ 436.96 ам.доллар бөгөөд өртөг нөхөх зардлын тайланд гэрээний үнээр тооцсон байна. Туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нэгж үнэ батлагдсан хөтөлбөр, төсвийн нэгж үнээс 32.85 ам.доллараар өндөр байгаа тул өртөг нөхөх зардлыг тооцохдоо хөтөлбөр, төсвийн нэгж үнээр тооцож, 3073256.55 ам.долларын өртөг нөхөх зардлаар баталгаажуулж, илүү зарцуулсан 345823.83 ам.долларыг хасах, - Гэрээлэгчийн 2012 оны өртөг нөхөх зардлын тайланд 13 цооногийн цэгийн координатыг 2320.77 ам.доллараар тодорхойлуулсан тухай тусгасан байна. Тус ажил нь батлагдсан хөтөлбөр, төсөвт тусгагдаагүй тул хасах, - 2012 онд өрөмдсөн 10 цооногт хийсэн шаврын судалгааны ажилд зарцуулсан 413242.45 ам.долларыг судалж үзээд 41286.36 ам.долларыг батлагдсан хөтөлбөр, төсвөөс давсан тул хасч, 371956.09 ам.долларыг өртөг нөхөх зардлаар баталгаажуулах, - 2013 онд өрөмдсөн 5 цооногт хийсэн шаврын судалгааны ажилд зарцуулсан 220251.03 ам.долларыг судалж үзээд 2389.14 ам.долларыг батлагдсан хөтөлбөр, төсвөөс давсан тул хасч, 217861.89 ам.долларыг өртөг нөхөх зардлаар баталгаажуулах саналыг тус тус гаргаж, баталгаажуулсан. Петрочайна дачин тамсаг ХХК-ийн 2012, 2013 онд өрөмдлөг, шаврын судалгаа, каротаж, хөндлөнгийн хяналтын ажилчин зэрэг ажилд зарцуулсан 241,810,582.38 ам.долларын зардлыг шалгаж анх шатны саналыг санхүүгийн хэлтсийн мэргэжилтэнд хүргүүлсэн. Тус саналаар 240,971,835.38 ам.долларын ажлын гүйцэтгэл, туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, хөтөлбөр, төсөв, тухай ажлын тайлан зэргийн шалгаж үзсний үндсэн дээр өртөг нөхөх зардлаар баталгаажуулж, 29,007.00 ам.долларыг хасах санал хүргүүлсэн. Мөн 809,740.00 ам.доллар нь хөндлөнгийн хяналтын хийсэн мэргэжилтнүүдийн цалин бөгөөд үүнийг хэд хоног ажилласан талаарх нотолгоо хангалтгүй байсан тул нягтлах шаардлагатай. Энэ ажлын хүрээнд Гадаадын ирган харъяатын газраас хэд хоног ажилласан талаар лавлага авч гэрээлэгчийн өгсөн мэдээлэлтэй тулгах ажил хийгдэж байна. Тосон-Уул XIX талбайд 2011 онд хийгдсэн цооногийн үйлчилгээний ажлууд болох шингэн хагалбар, перфораци, цооногийн засвар, үйлчилгээний ажлын		
--	--	---	--	--

		зардлыг урьдчилсан байдлаар 30,456,329.06 ам.доллараар, Тамсаг ХХИ талбайд 2011 онд хийгдсэн цооногийн үйлчилгээний ажлууд болох шингэн хагалбар, перфораци, цооногийн засвар, үйлчилгээний ажлын зардлыг урьдчилсан байдлаар 10,995,078.63 ам.доллараар тооцох саналыг гэрээлэгчид хүргүүлсэн. БХГ-97 талбайд үйл ажиллагаа явуулж буй Доншен газрын тос Монгол ХХК-ийн 2012, 2013 оны өрөмдлөг, шаврын судалгааны ажилд зарцуулсан зардлыг шалгаж дараах санал дүгнэлтийг гаргаж баталгаажуулсан. Үүнд: Шингэн хагалбарын ажилд: 2012 оны хөтөлбөр, төсвөөр 6 шинэ цооногт шингэн хагалбар хийхээр төлөвлөж 7 шинэ цооногт шингэн хагалбар хийсэн. Хуучин 14 цооногт шингэн хагалбар хийхээр төлөвлөж 12 хуучин цооногт шингэн хагалбарын ажил хийсэн буюу нийт 19 цооногт шингэн хагалбарын ажлыг хийсэн байна. Ажлын тайлангаар шингэн хагалбарын ажлын зардал 2812517.54 ам.доллар байна. Харин гэрээний дагуу тооцож үзэхэд 2812517.56 ам.доллар байгаа ба энэ нь ханшийн зөрүүтэй холбоотой гэж үзэв. Мөн 5 цооногийн ажлын зардал батлагдсан хөтөлбөр, төсвийн үнээс давсан байна. 2012 оны жилийн уулзалтаар байгуулсан протоколд "2012 оны хөтөлбөр, төсвөөр баталсан ажлуудын зардлын хэмжээ нь 2012 оны ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зардлын дээд хэмжээ гэж үзнэ" гэж заасны дагуу хөтөлбөр, төсвөөс давсан нэгж үнийг зөвшөөрөх боломжгүй юм. Иймд 19 цооногт хийсэн шингэн хагалбарын ажлын зардлыг 2706726.46 ам.доллараар тооцож, 105791.1 ам.долларын зардлыг хасах саналыг гаргаж баталгаажуулсан. Мөн шингэн хагалбарын ажилд зарцуулсан 1110166.11 ам.долларын шингэн хагалбарын керамзит элс болон бараа материалыг судалж үзэхэд хилээр оруулж ирсэн баримт байгаа боловч ашигласан нарийн задаргаа байхгүй, мөн уг материалын үнийг тооцвол батлагдсан хөтөлбөр төсвийн үнээс хэтэрч байгаа тул хөтөлбөр төсвийн үнэд багтаан 325241.5 ам.долларын бараа материалыг өртөг нөхөх зардалд тооцож хэтэрсэн 784924.57 ам.долларын бараа материалыг өртөг нөхөлтөөс хасах саналыг гаргаж баталгаажуулсан. Олборлолтын туршилтын ажилд: 2012 оны хөтөлбөр, төсөв, туслан гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээ, 2012 оны ажлын гүйцэтгэл, туслан гүйцэтгэгч компанийн нэхэмжлэл, ажлын мэдээ, тайлан зэргийг нарийвчлан судалсан болно. Ажлын зардлыг гэрээнд заасны дагуу дахин тооцоолсон болно. Бусад зардлыг цооногуудад тэнцүү		
--	--	---	--	--

118	208	5.2.4."Алт-2" хөтөлбөрийн хүрээнд алтыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулна. /ЗГҮАХ-2.69.5/ 1.Алт цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах боломж, нөхцөлийн талаар санал боловсруулж, суурь судалгааг хийх ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Судалгааны ажил хийгдсэн байна. Хугацаа: II улирал	Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж ажиллаж байна. Монголбанкны Ерөнхийлөгч болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/62, А/98 хамтарсан тушаалаар Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг барьж байгуулах талаар судалгаа хийж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсэг Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах боломжийн талаарх судалгааг хийж, санал дүгнэлтийг боловсруулан 2017 оны 11 дүгээр 22-ны өдөр УУХҮ-ийн сайдад танилцуулсан. /Биелэлт-100%/	40	
119	209	5.2.5.Дархан-Сэлэнгийн бүсэд байгуулах хар төмөрлөгийн цогцолбор төслийн ТЭЗҮ болон БОННУ-г боловсруулах ажлыг гүйцэтгэж дуусгана.	"Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн ТЭЗҮ болон БОННУ-ний дунд шатны тайлангуудыг хянаж, 2017 оны 2 сард хүлээн авсан. Түүнчлэн тус төслийн ТЭЗҮ-ийн эцсийн тайланг 2017 оны 9 дүгээр сард хүлээн авсан ба төслийн БОННУ-ний	28	

		/ЗГҮАХ-2.72.1/ 1.Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төслийн техник-эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний тайланг ШҮТЗ-өөр хэлэлцүүлж, хүлээн авна. Тоо хэмжээ: 1, Чанар: Тайланд хяналт тавьж, хүлээж авсан байна. Хугацаа: III улирал	тайлангийн олон нийтийн хэлэлцүүлэг хойшилсонтой холбоотойгоор үнэлгээний эцсийн тайланг Дэлхийн банкны MINIS төсөлтэй тохиролцсоноор 2018 оны 1 дүгээр улиралд хүлээж авахаар ажиллаж байна. / Биелэлт-90%/		
120	210	5.2.6.Давтах аргаар ган бөмбөлөг үйлдвэрлэх цехийг ашиглалтад оруулна. /ЗГҮАХ-2.72.2/ 1.Давтах аргаар ган бөмбөлөг үйлдвэрлэх цехийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: 1, Чанар: Үйлдвэрийг хүлээж авах улсын комисст яамнаас төлөөлөл ажиллуулна. Хугацаа: I улирал	“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК нь давтах аргын ган бөмбөлгийн үйлдвэрийг 2017 оны 01 сарын 28-нд ашиглалтад оруулсан. Үйлдвэрийн нээлтийн ажиллагаанд холбогдох мэргэжилтнүүдийн хамт оролцов. /Биелэлт-100%/	40	
121	211	5.2.7.Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулна. /ЗГҮАХ-2.72.3/ 1.Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: 1, Чанар: Үйлдвэрийн барилгын ажлын явцад хяналт тавина. Хугацаа: Жилдээ	Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажлыг эхлүүлэх төлөвлөгөө “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан ба тоног төхөөрөмжийн үнийн судалгаа, хөрөнгө оруулалтын арга замуудыг судалж байна. Төслийн шинэ ТЭЗҮ-д тусгаснаар хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдсэн тохиолдолд Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн барилгын ажлыг 2018 оны 8 дугаар сард эхлүүлж, 2020 оны 9 дүгээр сард дуусган мөн оны 12 сард ашиглалтад хүлээлгэн өгөхөөр тусгасан. Одоогийн байдлаар хөрөнгө оруулалт шийдэгдээгүй байна. /Биелэлт-100%/	12	
122	212	5.2.8. Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулж, импортын хэмжээг бууруулна.	УУХҮ-ийн сайд болон УБТЗ ХНН, Төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбооны төлөөллийг оролцуулсан уулзалтыг удаа дараа зохион байгуулж, төмөр замын тарифыг уян хатан болгох асуудлаар ярилцсан боловч УБТЗ ХНН-ийн удирдлага төмөр замын тарифыг бууруулах асуудлыг энэ онд шийдэх	12	

		/ЗГҮАХ-2.72.4/ 1.Төмрийн хүдэр, баяжмал экспортлох төмөр замын тээврийн тарифыг уян хатан болгох чиглэлээр “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй хамтран ажиллана. Тоо хэмжээ:1, Төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулж, импортын хэмжээг бууруулах чиглэлээр “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ТУЗ-өөр холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. Хугацаа:Жилдээ	боломжгүй талаар мэдэгдсэн. Мөн 2017 оны 11 дүгээр сард Төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбооны удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, холбогдох тооцоо судалгаа хийлгүүлэн, сайдад танилцуулан, дахин УБТЗ ХНН-т хандахаар ажиллаж байна. / Биелэлт-50%/		
123	213	5.2.9.Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулахыг бодлогоор дэмжинэ. /ЗГҮАХ-2.75.1/ 1.Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулах боломж, нөхцөлийн талаар судалгаа хийх ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Холбогдох судалгааны ажлыг хийсэн байна. Хугацаа: Жилдээ	Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж,машин механизм угсрах, автомашины эд ангиүйлдвэрлэх чиглэлээр Япон, Герман, БНХАУ, ОХУ-ын туршлагыг судалж, Япон Улсын Тоёота компанийн автомашины үйлдвэрлэлийн системийн талаар төслийн нэгжийн ажилтан газар дээр нь очиж танилцсан.Мөн Монгол улсад энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхэлж байгаа үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцаж мэдээллүүдийг нэгтгэн, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах боломж нөхцөлийн талаар судалгаа хийхажлыг 2017 оны 11, 12 дугаар сард зохион байгуулсан. /Биелэлт-100%/	40	
5.3. Газрын тос, уламжлалт бус газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрсийг хагас, гүн боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр байгуулах, бүтээгдэхүүнийг дотоод, гадаад зах зээлд борлуулах бодлогын удирдамжаар хангах					
124	214	5.3.1. "Газрын тос боловсруулах үйлдвэр" барих төслийн нэгж байгуулах, үйлдвэрийн дэд бүтцийн нарийвчилсан судалгаа, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэнэ. /ЗГҮАХ-2.70.1/ 1."Газрын тос боловсруулах үйлдвэр" барих төслийн нэгжийг байгуулах болон үйлдвэрийн газрын байршлын	Засгийн 2017 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 92 дугаар тогтоолоор Төсөл хэрэгжүүлэх Төрийн өмчит компани байгуулагдсан. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулж буй БНЭУ-ын EIL компанийн төлөөлөгчид, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд болон УУХҮЯ-ны ХҮБГ-ын МБШТМҮ-ийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд 2017 оны 9 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд Дорноговь аймагт албан томилолтоор ажиллаж тус аймгийн удирдлагууд болон Газрын албаны мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар аймгийн орон нутгийн удирдлагуудад	28	

		асуудлаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. Тоо хэмжээ: 1, Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдсан, үйлдвэрийн газрын асуудал тодорхой болсон байна. Хугацаа: II улирал	төслийн талаар танилцуулга хийж, үйлдвэр байгуулахад тохиромжтой газрыг урьдчилсан байдлаар газар дээр нь очиж судалсан.Мөн УУХҮ-ийн сайдын 2017 оны А/208 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг үйлдвэрийн байршлын талаар санал боловсруулсан. /Биелэлт-90%/		
	215	2.Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгаврыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1, Ажлын даалгавар батлагдаж, холбогдох судалгааны ажил хийгдсэн байна. Хугацаа: III улирал	УУХҮСайдын 2017 оны А/26 дугаар тушаалаар Монгол улсын Засгийн газар болон БНЭУ-ын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн нарийвчилсан техник,эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажлын даалгаврыг монгол, англи хэл дээр боловсруулан 2017 оны 4 дүгээр сард батлуулсан.Уг ажлын даалгаврын дагуу үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ хийгдэж байна. /Биелэлт-100%/	40	
125	216	5.3.2.Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангана. /ЗГҮАХ-2.70.2/ 1.Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. Тоо хэмжээ: 1, Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээ тодорхой болсон байна. Тоо хэмжээ: II улирал	Сангийн яамтай хамтран Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, ЗГ-ын 2017.2.17-ны өдрийн хуралдаанаар "Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай" 59 дүгээр тогтоолыг батлуулсан.Уг тогтоолоор Монгол улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импорт банк хоорондын 1,0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийг хэрэгжүүлэхээр тогтсон.Тус тогтоолын дагууМонгол улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импорт банк хооронд 2016 онд байгуулсан зээлийн хэлэлцээрийн зориулалтыг өөрчлөх асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн бөгөөд УИХ-ын хаврын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн батлуулснаар төслийн санхүүжилтийн асуудал шийдэгдэв. /Биелэлт-100%/	40	
	217	2.Төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1, Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хангагдсан байна. Тоо хэмжээ: II улирал	БНЭУ-аас олгох хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжих "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн менежментийн Зөвлөх үйлчилгээ үзүүлэх /PMC / компанийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг болон ажлын даалгаврыг монгол, англи хэл дээр боловсруулж байна. /Биелэлт-50%/	28	

126	218	5.3.3. Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл, барилгын зураг төслийг боловсруулна. /ЗГҮАХ-2.70.3/ 1.Нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах компанийг БНЭУ-ын "Экспорт" банкнаас ирүүлсэн Зөвлөх компаниудын жагсаалтаас сонгон шалгаруулна. Тоо хэмжээ: 1, Нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах компанийг сонгон шалгаруулсан байна. Хугацаа: Жилдээ	УУХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны А/16 тоот тушаалаар “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн нарийвчилсан техник,эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх компанийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо нь “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн зөвлөх компанийг сонгон шалгаруулсан бөгөөд тус компанитай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2017 оны 8 дугаар сарын 09-ний өдөр байгуулан ажиллаж байна. /Биелэлт-100%/	40	
	219	2.Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусган Засгийн газарт танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулна. Тоо хэмжээ: 1, Нарийвчилсан ТЭЗҮ-г Засгийн газарт танилцуулсан байна. Хугацаа: Жилдээ	Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулж буй БНЭУ-ын EIL компанийн 2017 оны 10 дугаар 12-ны өдөр ирүүлсэн эхлэлийн тайланг хянаж, уг тайланд захиалагчийн зүгээс тусгах санал, дүгнэлтийг 2017.10.20-ны өдрийн 08/2211 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу Зөвлөх компаниас төслийн суурь судалгааны болон эхлэлийн тайланг Захиалагчийн санал, дүгнэлтийг тусган, 2017 оны 11 дүгээр 14-ний өдөр эцсийн байдлаар шинэчлэн ирүүлсэн. /Биелэлт-50%/	28	
128	221	5.3.5.Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн нэгжийг байгуулна. /ЗГҮАХ-2.73.1/ 1.Төслийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны төсөв болон төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавина. Тоо хэмжээ: 1, Чанар: Төслийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг батлагдсан байна. Хугацаа: I улирал	Засгийн газраас 2016 онд баталсан 107 дугаар тогтоолоор “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” барих төслийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулахаар шийдвэрлэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/43 дугаар тушаалаар Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн нэгжийг байгуулан ажиллаж байгаа ба Төслийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. 2017 оны Төсвийн тодотголоор үйл ажиллагааны төсөв нь батлагдан ажиллаж байна. /100%/	40	

129	222	5.3.6. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авна. /ЗГҮАХ-2.73.2/ 1. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, хүлээн авна. Тоо хэмжээ: 1, Чанар: Тайланг ШУТЗ-өөр хэлэлцүүлж, хүлээн авсан байна. Хугацаа: I-II улирал	"Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр холбогдох мэргэжлийн хүмүүсээр хэлэлцүүлэн хүлээн авсан. /100%/	40	
130	223	5.3.7. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ болон БОННУ-г Хүнд үйлдвэрийн Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ. /ЗГҮАХ-2.73.3/ 1."Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөл нөлөөллийн үнэлгээг Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ. Тоо хэмжээ: 1, Чанар: Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж холбогдох дүгнэлтийг гаргуулсан байна. Хугацаа: II улирал	"Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2017 оны 05 сарын 4-ний өдөр УУХҮЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. / Биелэлт-100%/	40	
131	224	5.3.8. Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангана. /ЗГҮАХ-2.73.4/	Монгол Улсын Ерөнхий сайдын 113-р тоот захирамжаар байгуулагдсан "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдааныг 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Газрын дарга Б.Баатарсүх болон "Нүүрснээс нийлэг байгалын хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн нэгжийн төлөөлөл 2017 оны 11 дүгээр 20-	12	

		1.Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ Тоо хэмжээ: 1, Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээ тодорхой болсон байна. Тоо хэмжээ: II улирал	ны өдөр Төв аймгийн Баяндэлгэр суманд очиж, орон нутгийн удирдлагуудад ННБХҮҮ-ийн төслийн талаар танилцуулга хийж, харилцан санал бодлоо солилцов.Мөн Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээг тодорхой болгох зорилгоор Төслийн нэгжээс хуулийн зөвлөх үйлчилгээний “Без Партнерс” ХХН-тэй зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр байгуулан ажиллаж, холбогдох судалгааг хийж баримт бичгийг боловсруулаад байна. /Биелэлт 50%/		
	225	2.Төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1, Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хангагдсан байна. Тоо хэмжээ: II улирал	Хөрөнгө оруулагчийг татах зорилгоор Япон, БНХАУ, ОХУ, Европын орнуудад хөрөнгө оруулагчдын форумд оролцох, сурталчлах ажлуудыг зохион байгуулсан. Мөн энэчиглэлээр холбогдох саналыг 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр боловсруулж, сайдад танилцуулахаар бэлтгэсэн болно. /Биелэлт 75%/	12	
132	226	5.3.9 Улаанбаатар хотод жилд 15000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжинэ. /ЗГҮАХ-2.74.1/ 1.Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллана. Тоо хэмжээ: 1, Үйлдвэр байгуулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна. Тоо хэмжээ: II улирал	Хүнд үйлдвэрийн бодлогын газрын даргын урилгаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй шингэрүүлсэн хийн /LPG/ жижиглэнгийн худалдаа хийдэг бизнесийн эрхлэгч компанийн төлөөлөлтэй 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Үйлдвэрийн ТЭЗҮ-г Германы EDL компани боловсруулж ШУТЗ-өөр хэлэлцүүлсэн. /Биелэлт 50%/	12	
6.0. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОХИЦУУЛАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:					
6.1. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах гол зорилтын хүрээнд:					
138	236	6.1.6. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул судалгаа, ашиглалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ЗГҮАХ-2.59.7/ 1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг	-Уул уурхайн, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/51 тоот тушаалаар байгуулагдсан “Монгол Улсын хэмжээнд цацраг идэвхт ашигт малтмал эрэх хайх, олборлох, боловсруулах үйл ажиллагааны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх асуудлаар санал боловсруулж ажиллах үүрэг бүхий” Ажлын хэсэг ажиллаж, санал дүгнэлт боловсруулж, удирдлагад танилцуулсан.	20	

		дахин хэлэлцүүлэх ажлыг холбогдох арга хэмжээг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	-Хууль зүй, дотоод хэргийн яам болон Германы GIZ төсөлтэй хамтран гүйцэтгэсэн багц хуулийн төслийн хүрээнд “Цөмийн энергийн тухай” хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах тухай хуулийн төсөл дээр ажилласан бөгөөд өмнө боловсруулсан Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж хүргүүлсэн. /Биелсэн-100%/		
	237	2.Цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийн ангиллын заавар боловсруулна. Тоо хэмжээ:1 удаа, Чанар: Хуульд нийцсэн заавар гарсан байна. Хугацаа: Жилдээ	Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хэлэлцүүлэх асуудалд оруулахаар санал хүргүүлсэн хэдий ч буцаагдсан. /Үнэлэх боломжгүй/	/-/	
6.2. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг гэрээ хэлцэлд бэлтгэх, хэрэгжилтийг зохицуулах гол зорилтын хүрээнд:					
140	241	6.2.5. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулна. /ЗГҮАМХ-2.59.9/ 1.Орд ашиглах гэрээ байгуулсан Арева-Майнс компани болон Гурвансайхан компаниудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэх, хамтарсан компаниудын үйл ажиллагааг эхлүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. Тоо хэмжээ:1 удаа, Чанар: Хуульд нийцсэн байна. Хугацаа: Жилдээ	-Орд ашиглах гэрээ байгуулсан “Арева-Майнс” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэх ажлыг Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж “Мон-Атом” ХХК-д тус хамтарсан компанийн 34 хувийг шилжүүлсэн. -“Гурвансайхан” ХХК-ийн эзэмшиж буй орд газруудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэх ажлыг зохион байгуулахаар орд эзэмшигч төрийн өмчит компаниудтай ярилцан тохиролцох ажлыг зохион байгуулж байна. /Биелсэн-100%/	36	
6.3. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн бодлого, улсын төсөв, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулалтаар хангах гол зорилтын хүрээнд:					
142	244	6.3.6. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн	“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах Сайдын 2017 оны А/15 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хүрээнд журмын төслийг шинэчлэн боловсруулсан.	40	

		зохицуулалтыг боловсронгуй болгоно. /ЗГҮАХ-2.64.1, 2.64.2/ 1.“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Журам шинэчлэн боловсруулсан байна. Хугацаа: 1 улиралд	/Биелсэн-100%/		
	245	2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ. Тоо хэмжээ: 1, Чанар: Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байна. Хугацаа: 1-2 улиралд	“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлуулсан. /Биелсэн-100%/	40	
	246	3. Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна. Тоо хэмжээ: 1, Чанар: Хуульд нийцсэн байна. Хугацаа: Жилдээ	Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг зохион байгуулалтад оруулах, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн шинэчлэн байгуулахаар ажиллаж байна. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” дэд зөвлөлийн төлөвлөгөө, хуралдаанд 2017 оны 9, 11 саруудад санал өгч, илтгэл тавьж тогтмол оролцсон. /Хэрэгжих шатанд-70%/	20	
143	247	6.3.7. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. /ЗГҮАХ-2.69.6, 2.69.7/ 1. Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ Тоо хэмжээ: 1, Чанар: Алтны уурхай, баяжуулах үйлдвэр ашиглалтад орсон байна. Хугацаа: Тухай бүр	Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-т заасны дагуу алт олборлохоор 14 аж ахуйн нэгж хүсэлтийг судалж, шийдвэрлэсэн. /Биелсэн-100%/	40	

	248	2. Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалгаа хийж, хэрэгжүүлнэ. Тоо хэмжээ: 1, Чанар: Судалгаа хийгдсэн байна. Хугацаа: Тухай бүр	-Судалгааг Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран хийхээр төлөвлөсөн бөгөөд судалгаа хийгдэж байна. -Мөн сайдын тушаалаар холбогдох байгууллагын төлөөлөл орсон ажлын хэсэг байгуулахаар санал авч байна. -Улсын төсвийн хөрөнгөөр 2017 оноос шинээр эхлүүлэх сэдэвчилсэн судалгааны Монгол орны Төв, Зүүн бүсийн алтны хүдэржилт, хэтийн төлөвийг үнэлгээ төслүүдийн төлөвлөлтийн санал, геологийн даалгаврын төсөлд санал хүргүүлсэн. -Төв, Зүүн Монголын алтны хүдэржилтийн судалгаа төслийг 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ оны хээрийн судалгааны ажлын анхдагч баримт, материалыг хүлээн авсан. /Биелсэн-100%/	12	
144	249	6.3.9. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ-2.61.4/ 1.Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: 1, Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ	-“Алт-2” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийн үр ашигтай буюу нөөц, Техник эдийн засгийн үндэслэл батлуулсан аж ахуйн нэгжүүдэд Засгийн газраас Хөгжлийн банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгож байна. -Ашигт малтмалын тухай хуулийн 35.4-д заасны дагуу ашиглалтад оруулахад бэлэн болсон уурхай, уулын үйлдвэрийг хүлээн авах Улсын комисс ажиллаж байна. /Биелсэн-100%/	36	
6.4. Салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах гол зорилтын хүрээнд:					
146	253	6.4.2. Уул уурхайн салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сан бүрдүүлнэ. 1.Уул уурхайн бүтээгдэхүүн олборлолтын статистик мэдээллийг нэгтгэх, нийтэд ил тод мэдээлнэ. Тоо хэмжээ: 4, удаа Чанар: Мэдээлэл нэгтгэсэн байна. Хугацаа: Улирал бүр	-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын “Ашигт малтмал, газрын тосны газраас мэдээ, тайлан ирүүлэх журам”, “Мэдээ тайлан ирүүлэх хуваарь”-ийг сайдын 2016 оны 11 дүгээр сарын 29 өдрийн А/60 тоот тушаалыг батлуулан, тушаалын хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. -Сар бүрийн уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн статистик мэдээллийг нэгтгэн уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудсанд байршуулж байна. /Биелсэн-100%/	40	
7.0. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТ ХИЙХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:					
7.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөр төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж үр дүнг нь үнэлж дүгнэх, дүгнэлт зөвлөмж гаргах гол зорилтын хүрээнд:					

149	258	7.1.1 Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-2013-322-ийн 17/ 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг сайдын зөвлөлд танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлнэ. Тоо хэмжээ: 2 удаа, Чанар: Шийдвэр заалтыг бүрэн хамарсан байна. Хугацаа: 01/15, 07/10-ны дотор	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар гарсан нийт 289 шийдвэрийн 416 заалтад 2016 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж боловсруулсан. Тогтоол шийдвэрийн биелэлт жилийн эцсийн байдлаар 86.2%тай дүгнэсэн. Хяналтад авсан эрх зүйн баримт бичгийн 289 шийдвэрийн 416 заалтын биелэлтийг ЗГХЭГ-ын www.unelgee.gov.mn цахим хуудсанд шивж, баталгаажуулав. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүнг удирдлагын зөвлөлийн УЗХ-аар хэлэлцүүлэн 01/133 тоот албан бичгээр ЗГ-ын ХЭГ-т хүргүүлсан. -2017 оны эхний хагас жилийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 135 шийдвэрийн 188 заалтыг хяналтанд авч хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 83.0 хувийн биелэлттэй дүгнэсэн. Үүнд: Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 8 шийдвэрийн 10 заалтын хэрэгжилт 81.7%, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 31 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилт 82.0%, уул уурхайн бодлогын асуудлын 32 шийдвэрийн 52 заалтын хэрэгжилт 73.0%, хүнд үйлдвэрийн бодлогын асуудлын 32 шийдвэрийн 46 заалтын хэрэгжилт 83.0%, нийтлэг асуудлын 34 шийдвэрийн 49 заалтын хэрэгжилт 87.8 хувийн тус тус биелэлттэй. Үнэлгээний дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 06/30-ны өдрийн 01/1549 тоотоор ХЭГ-т газарт хүргүүлж, ХЭГ-ын unelgee.gov.mn сайтад байршуулж баталгаажуулсан. Мөн яамны цахим хуудаст байршуулж ил тод байдлыг хангаж ажиллав. / Биелэлт-100%/	40	
	259	2. Бүрэн хэрэгжсэн шийдвэр, заалтыг хяналтаас хасуулах тухай санал, тайлбарыг тодорхой дурдсан жагсаалтыг хууль, тогтоомжийн хэрэгжилтийн тайлангийн хамт хүргүүлнэ. /ЗГ-2013-322-ийн 14/ Тоо хэмжээ: 2 удаа, Чанар: Хяналтаас хасуулах санал үндэслэлтэй байна. Хугацаа: 01/15, 07/10-ны дотор	Мөн чиг үүрэг болон хариуцах асуудлын хувьд тус яаманд хамааралгүй болон бүрэн хэрэгжсэн 100 хувийн биелэлттэй зарим шийдвэрүүдийг тайлбарын хамт 2017 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр ЗГ-ын ХЭГ-т цахимаар хүргүүлж, хяналтаас хасуулсан. Үүнд: МУ-ын хууль 5, УИХ-ын 3 тогтоолын 6 заалт, Ерөнхийлөгчийн зарлиг 1, Засгийн газрын 87 тогтоолын 39 заалт, Засгийн газрын хуралдааны 33 тэмдэглэлийн 34 заалт хамаарч байна. / Биелэлт-100%/	40	
150	260	7.1.2 “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийн I үе шатны	Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичигт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан 4 зорилтын I үе шат /2016-2020 он/-ны биелэлтэд 2016 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээг	40	

		зорилтын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. 1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг холбогдох газрууд болон харьяа агентлагаас 2016 оны жилийн эцсийн байдлаар зорилт бүрээр үнэлгээ хийж, дүнг сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ЗГХЭГ-т хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Арга хэмжээ бүрийг хамруулсан байна. Хугацаа: 2017/02/01-ний дотор	хийв. Бодлогын баримт бичгийн аж үйлдвэрийн салбарын химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах зорилт, хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах зорилт, геологийн салбарын хөгжлийг дэмжих зорилт, ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилт, нийт 4 гол зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн дундаж 50,0%-тай дүгнэсэн. -Үнэлгээг яамны нэгдсэн тайланд нэгтгэж удирдлагын зөвлөлийн 3 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/736 тоот албан бичгээр ЗГ-ын ХЭГ-т хүргүүлсэн. / Биелэлт-100%/		
151	261	7.1.3 Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. 1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд арга хэмжээ бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ЗГХЭГ-т хүргүүлнэ. /ЗГ-2013-322-ийн 17/ Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Тайланг хүргүүлсэн байна. 2017/02/01, 07.10-ны дотор	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 36 зорилтын 105 арга хэмжээг хяналтад авч сайдын 2017 оны А/22 дугаар тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан 105 арга хэмжээ, үүнээс үндсэн хэрэгжүүлэгчээр 76, хамтран хэрэгжүүлэх 28, оролцогчоор хэрэгжүүлэх 1 арга хэмжээний биелэлтэд 2016 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн. Яам толгойлон хэрэгжүүлэх 76 арга хэмжээний биелэлт 23.0%, хамтран хэрэгжүүлсэн 28 арга хэмжээний биелэлт 18,3%-тай, нийт арга хэмжээ 22,4%-ийн биелэлттэй дүгнэсэн. Үнэлгээний дүнг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулан, тайланг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/284 тоотоор ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулж ажилласан. -2017 хагас жилийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний unelgee.gov.mn цахим системд байршуулсан 28 зорилтын 85 арга хэмжээний хүрээнд хийсэн. Биелэлт гаргаж үнэлгээ хийсэн 85 арга хэмжээнээс 65 арга хэмжээг яам толгойлон, 20 арга хэмжээг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн. Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын хүрээний 1 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 50.0 хувь, Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын хүрээний 22 зорилтын 73 арга хэмжээний биелэлт 58,3 хувь, Нийгмийн бодлогын хүрээний 1	40	

			зорилтын 1 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөөгүй, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 4 зорилтын 8 арга хэмжээний биелэлт 40,0 хувь, эхний хагас жилд хэрэгжүүлсэн нийт 85 арга хэмжээний биелэлтийг 57,5 хувьтай дүгнэж, дүнг 06/30-ны өдрийн 01/1535 албан бичгээр ХЭГ-т хүргүүлж, ХЭГ-ын unelgee.gov.mn сайтад байршуулан баталгаажуулсан. Үнэлгээний тайлан, дүгнэлтийг яамны цахим хуудсанд байршуулж, ил тод байдлыг хангасан. -Хууль тогтоомжийн хэрэгжилт, ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, 2016 оны Үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн х/ш/ү-ний тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулж тайланг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/284 тоотоор ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан. Хөтөлбөрийн 2017 оны хагас жилийн дүнг 06/30-ны өдрийн 01/1535 албан бичгээр ХЭГ-т хүргүүлсэн. / Биелэлт-100%/		
152	262	7.1.4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-2013-322-ийн 17/ -2016 оны Үндсэн чиглэлийн биелэлтэд жилийн эцсийн байдлаар, 2017 оны Үндсэн чиглэлийн биелэлтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж СЯ-нд хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Тайланг хүргүүлсэн байна. Хугацаа: 2017/02/01, 07.10-ны дотор	- Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 сарын 11-ний өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 15 зорилт, арга хэмжээний 1 зорилт, арга хэмжээг үнэлэх боломжгүй, 4 зорилт, арга хэмжээ 100%, 4 зорилт, арга хэмжээ 90%, 6 зорилт, арга хэмжээ 70%, ерөнхий дүнгээр 84.2 хувийн биелэлттэй дүгнэсэн. Үнэлгээний тайланг 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/256 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ЗГХЭГ-ын unelgee.gov.mn сайт, яамны цахим хуудсанд тус тус байршуулсан. Үнэлгээний тайланг яамны 2016 оны нэгдсэн тайланд нэгтгэсэн. - УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын 2017 оны 29 дугаар тогтоолоор батлагдсан, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 6 зорилтын 26 арга хэмжээг арга хэмжээг хяналтад авч ажиллав. Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2017 оны хагас жилийн биелэлт 72,3 хувьтай үнэлсэн. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс 10 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 8 арга хэмжээ 70 хувь, 8 арга хэмжээ 40 хувийн тус тус хэрэгжилттэй, тасарсан арга хэмжээ байхгүй. Үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ЗГХЭГ-ын unelgee.gov.mn сайт, яамны цахим хуудсанд тус тус байршуулсан.	40	

			-Эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн х/ш/ү-ний тайланг 2017 оны 1 сарын 31-ний өдрийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулж тайланг 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/256 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажилласан. -Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хагас жилийн биелэлтэд хийсэн х/ш/ү-ний тайланг 2017 оны 6 сарын 22-ны өдрийн Удирдлагын зөвлөлийн 5-р хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулж тайланг 6 сарын 23-ны өдрийн 01/1459 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажилласан. / Биелэлт-100%/		
7.2. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, гэрээний хэрэгжилт болон иргэд байгууллагын мэдээлэл, өргөдөл гомдлын мөрөөр дотоодын хяналт, шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт гаргах гол зорилтын хүрээнд:					
159	269	7.2.1. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдлын мөрөөр дотоодын хяналт, шалгалт хийнэ. /ЗГ-2012-63/10/-ийн 2.5.4.2/ -Хууль тогтоомжийн хүрээнд дотоодын хяналт, шалгалт хийнэ. Тоо хэмжээ: /-/ , Чанар: Хууль тогтоомжийн хүрээнд ажиллана. Хугацаа: Тухай бүр	Нийт 12 өргөдөл, гомдол ирснээс 3 өргөдлийг судлаж шийдвэрлэж хариуг хүргүүлсэн, 9 өргөдөл шийдвэрлэгдэх шатанд байна. Дараах аж ахуйн нэгж, иргэний гомдлын мөрөөр дотоодын хяналтыг хийж гүйцэтгэв. Үүнд: -“Өсөх судал” ХХК-ний гаргасан цахим дугаар олголтыг хүчингүй болгосон шийдэртэй холбогдох гомдол, -Иргэн З.Ганчимэгийн, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн нөөцийн талаар гаргасан гомдол, -Иргэн Ц.Чинбатын, Оюу толгой ХХК ажлын байрны сонгон шалгаруулалтаас хассан талаар гаргасан гомдлыг тус тус шийдвэрлэж хариуг өгсөн байна. -Тайлангийн хугацаанд нийт 114 албан тоот хүлээн авснаас хариугүй албан тоот 77, хариутай 37 албан тоот байгаагаас 31 бичгийн хариуг шийдвэрлэсэн, шийдвэрлэх шатанд 6 бичиг байна.	36	
7.4. Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гаргах гол зорилтын хүрээнд:					
177	290	7.4.7. Замын-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын санхүү аж ахуйн үйл ажиллагаанд аудит хийнэ. -Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын санхүү аж ахуйн үйл ажиллагаанд аудит хийж, дүнг удирдлагын зөвлөлд танилцуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Удирдлагыг эрсдэлийн удирдлагаар хангасан байна.	УУХҮСайдын 2017.04.24-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/87 дугаар тушаалаар Замын-Үүд дэх "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" Төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийх бүрэлдэхүүн, удирдамжийг батлуулж, удирдамжийн дагуу 2017 оны 04 сарын 28-30-ны өдрүүдэд ажиллаж, аудитын тайланг удирдлагад танилцуулж ажилласан. / Биелэлт-100%/	40	

		Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд			
180	293	7.4.10. АМГТГ-ын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд аудит хийх Агентлагийн санхүү аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит хийж дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг удирдлагын зөвлөлд танилцуулна. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Удирдлагыг эрсдэлийн удирдлагаар хангасан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	УУХҮЯ-ны Сайдын А/221 дүгээр тушаалаар Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг батлуулж, удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж шалгалтын нэгдсэн дүнг сайдад танилцуулж ажилласан. / Биелэлт-100%/	40	
Тусгай захиалгат арга хэмжээний биелэлтийн дундаж				34,6	

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

ХАХ	ГАҮ	Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)	Тухайн манлайллын зорилтын биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (зорилт бүрийн биелэлтэд 0-30 оноо)	
				ХШҮ ДАГ	ТЕЗ
1	2	3	4	5	6
1	1	1.Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар: Зорилт-1: Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахин ажиллана.	1/ Шинээр ажилд орсон албан хаагчдад Төрийн албаны ёс зүй харилцааны соёлын талаар тусгай хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг танилцуулан албан хаагч тус бүрээр гарын үсэг зуруулан хувийн хэрэгт хавсаргаад байна. Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын байрны бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “5С буюу Кайзен менежмент ба байнгын сайжруулалт”, “Харилцааны ур чадвар”, “Цаг төлөвлөлт болон хувийн зохион байгуулалт” сэдвүүдээр Монголын хүний нөөцийн институтээс	30	

		-Байгууллагын ажилчдыг ёс зүйн чиглэлээр сургалтад хамруулна. Тоо: 1 удаа, Чанар: Ёс зүйн сургалт зохион байгуулсан байна. Хугацаа: 3 дугаар улиралд	2017 оны 12 дугаар сарын 25, 27-ны өдрүүдэд сургалт авахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. / Биелэлт-100%/		
	2	Зорилт-2: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөн ажиллана. - Өөрийн болон байгууллагынхаа бүх албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гаргуулах ажилд хяналт тавина. Тоо: 1 удаа, Чанар: Хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авч холбогдох газарт тайлагнасан байна. Хугацаа: 1 дүгээр улиралд	2/ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөн ажиллаж уг асуудлаар ажиллагсдад мэдээлэл өгч АТГ-ын СГХ-тэй хамтран ажиллаж мэдээллийн цаг зохион байгуулж ажилласан. Өөрийн болон байгууллагын албан хаагчдын ХОМ-г хуулийн хугацаанд нь авч, тайлан мэдээллийг холбогдох газарт хүргүүлсэн. / Биелэлт-100%/	30	
2	1	2.Байгууллагын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр ажил зохион байгуулна. - Байгууллагын вэб хуудсанд цаг үеийн мэдээллийг тухай бүр оруулах, нээлттэй ажлыг зохион байгуулна. Тоо: Байнга, Чанар: Үйл ажиллагаа ил тод байна. Хугацаа: Жилдээ	1/Байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор яамны вэб сайтад тусгай мэдээллүүдийг оруулан хяналт тавин ажиллаж байна. Илт тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, холбогдон гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Салбарын мэдээ, мэдээллийг сар бүр Ил тод уул уурхай сэдэвт хэвлэлийн бага хурал зохион байгуулж олон нийтэд нээлттэй мэдээллийг шуурхай өгч ажиллаж байна. /Биелэлт-100%/	30	
3	1	3.Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийг мөрдөж ажиллана. -Батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийж ажиллана.	“Шилэн дансны тухай” хуулийн хүрээнд: Засгийн газрын шилэн дансанд хуулиар тогтоосон хугацаанд дараах мэдээллүүдийг тавьж, ил тод байдлыг ханган ажиллаж байна. Үүнд: -УУХҮ-ийн сайдын 2017 оны батлагдсан төсөв, түүнд орсон өөрчлөлт -Батлагдсан хөтөлбөр, түүний биелэлт -Худалдан авах ажиллагаанд хийсэн шалгалтын үнэлэлт, дүгнэлт Тендерийн мэдээлэл -Хөрөнгө, зардал гаргах тухай шийдвэрүүд	30	

		Тоо: Байнга, Чанар: төсвийг үр ашигтай зарцуулах, Хугацаа: Жилдээ	-Хөрөнгийн болон концессын санхүүжилт УУХҮ-ийн сайдын 2017 оны орлогын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл -УУХҮ-ийн сайдын багцын гүйцэтгэл -Аудитлагдсан тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмж Засгийн газрын цахим худалдан авах ажиллагааны системд дараах мэдээллүүдийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажиллаж байна. Үүнд: -УУХҮ-ийн сайдын 2017 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө -Дээрх төлөвлөгөөнд орсон өөрчлөлтүүд -Тендерийн үнэлгээний хорооны шийдвэр -Үнэлгээний хорооны бүрэлдэхүүний мэдээлэл -Тендерийн урилга -Хураангуй жагсаалтад орсон тендерт оролцох саналын урилга -Тендерийн баримт бичиг -Тендерт оролцогчдын ажлын даалгавар Мөн АТГ-ын хяналт шалгалтынханд шилэн дансны мэдээллийн байршуулалт, ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа талаар шалгуулж сайшаагдав. / Биелэлт-100%/	30	
	2	Зорилт-2: 2017 оны Төсвийн тухай хуулийн хүрээнд төсвийг зарцуулна.			
4	1	4.Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар: Зорилт-1: Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын эд хөрөнгийг зохицуулна. -Байгууллагын өмч хамгаалах комиссыг байгуулж ажиллана. -Байгууллагын эд хогшлыг нэгдсэн бүртгэлд оруулна. Тоо: 2, Чанар: Нэгдсэн бүртгэлд орж эд хөрөнгө бүрийг эзэнтэй болгосон байна. Хугацаа: Жилдээ	Яамны өмч хамгаалах комиссыг ТЗУГ-ын даргаар ахлуулан байгуулсан. Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын эд хөрөнгийг зохицуулан ажиллаж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар яамны өмч хамгаалах комиссоос нэгдсэн тооллого хийж эд хөрөнгийн бүртгэлийг хийж албан хаагч тус бүрээр карт хөтлөн баталгаажуулаад байна. /Биелэлт-100%/	30	

5	1	5.Байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх талаар: Зорилт-1: Байгууллагын ажилчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх талаар гадаад, дотоодын сургалтыг зохион байгуулна. -Сургалтын төлөвлөгөө гаргана. -Салбарын хүний нөөцийн судалгаа гаргаж, нэгдсэн дүгнэлтэд хүрнэ. -Гадаад, дотоодын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллана. Чанар: Хүний нөөцийн чадавх дээшилсэн байна. Хугацаа: жилдээ	Яаманд ирүүлсэн сургалтын мэдээллийг тухай бүр нь удирдлагад танилцуулж, албан хаагчдыг хамруулах арга хэмжээг авч ажилласан. Тайлант хугацаанд яамны албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, чадавхжуулах гадаадын 16, дотоодын 51 сургалт, семинар зохион байгуулагдаж, давхардсан тоогоор нийт 153 албан хаагчдыг хамруулаад байна. /Биелэлт 100%/	30	
	2	Зорилт-2: Мэргэжил дээшлүүлэх хүсэлтэй албан хаагчдад сурах нөхцөлөөр хангаж дэмжлэг үзүүлнэ.	2017 оны жилийн эцсийн байдлаар Гадаадад 26 албан хаагч мэдлэг олгох богино, дунд хугацааны сургалтад, Дотоодод 127 албан хаагчийг мэдлэг, мэргэшил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулаад байна. Удирдах зарим албан хаагчдыг Төрийн удирдлагын академиас зохион байгуулсан сургалтуудад төлөвлөгөөний дагуу хамруулсан. / Биелэлт-100%/	30	
Манлайллын зорилтын биелэлтийн дундаж				30,0	
ДУНДАЖ ОНОО					

Тайлан бичсэн:

Үнэлгээ өгсөн:

Төсвийн ерөнхийлөн захирагч:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

.....

/Д.СУМЪЯАБАЗАР/

(албан тушаал)

(гарын үсэг)

(тэмдэг)

.....

(огноо)

Төсвийн шууд захирагч:

Төрийн нарийн бичгийн дарга

.....

/Г.НАНДИНЖАРГАЛ/

(албан тушаал)

(гарын үсэг)

(тэмдэг)

.....

(огноо)